



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2019 ОНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2020 ОН

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар

5

Нэг. Үндэсний статистикийн салбарын 2019 оны үйл ажиллагааны тайлангийн хураангуй

5

Хоёр. Монгол Улсын статистикийн салбарын 2019 оны зорилго, зорилтын хэрэгжилт, үр дүн

8

2.1 Алба ёсны статистикийн мэдээлэл, тооллого, судалгаа.....	8
2.2 Тогтвортой хөгжлийн зорилгын шалгуур үзүүлэлтүүд.....	12
2.3 Анхан шатны мэдээний чанар, шуурхай байдлыг дээшлүүлэх.....	13
2.4 Аргачлал, ангиллыг боловсронгуй болгох.....	17
2.5 Үндэсний тооцоо, шинжилгээ судалгаа.....	18
2.6 Мэдээллийн технологи.....	19
2.7 Мэдээлэл тархаалт.....	20
2.8 Удирдлага, зохион байгуулалт.....	23
2.9 Гадаад харилцаа, хамтын ажиллагаа.....	24
2.10 Хүний нөөц, статистикийн сургалт.....	26
2.11 Санхүүгийн үйл ажиллагаа.....	28

Гурав. Монгол Улсын статистикийн салбарын 2020 оны зорилго, зорилт

29

Дөрөв. Байгууллагын үйл ажиллагаанд хийсэн системчилсэн үнэлгээний тайлан

30

ХАВСРАЛТ

37

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ААНБТ	Аж ахуйн нэгж, байгууллагын тооллого
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АНДОЭЗНК	Ази, Номхон Далайн орнуудын Эдийн засаг, нийгмийн комисс
АНДОСИ	НҮБ-ын Ази, Номхон Далайн орнуудын статистикийн институт
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АҮ	Аж үйлдвэр
АХБ	Азийн хөгжлийн банк
АХС	Ажиллах хүчний судалгаа
АХСА	Ажиллах хүчний судалгааны алба
АТҮТ	Авто тээврийн үндэсний төв
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БӨЭЗД	Байгаль орчин, эдийн засгийн данс
БӨЭЗДС	Байгаль орчин, эдийн засгийн дансны систем
БНСЭЭС	Байгалийн нөөцөд суурилсан эдийн засгийн судалгаа
БОСТ	Байшин, орон сууцны тооллого
БСГ	Боловсрол соёлын газар
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БР	Бизнес регистр
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ГИХГ	Гадаадын иргэн, харьяатын газар
ГХЯ	Гадаад харилцааны яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗТХЯ	Зам тээврийн хөгжлийн яам
МҮОНРТ	Монголын үндэсний олон нийтийн радио телевиз
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
НЭМГ	Нийслэлийн эрүүл мэндийн газар
ОУВС	Олон улсын валютын сан
ӨНЭЭС	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа

ӨОЗСА	Өрхийн орлого, зарлагын судалгааны алба
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УИХ	Улсын Их Хурал
ҮДТ	Үндэсний дата төв
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАӨМС	Хүн ам, өрхийн мэдээллийн сан
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМХТ	Эрүүл мэндийн хөгжлийн төв
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭЗҮАСА	Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал
ANCSDAAP	Ази, Америк, Номхон далайн орнуудын Үндэсний тооллого, Статистикийн байгууллагын дарга нарын нийгэмлэг
ESRI	НҮБ-ын Байгаль орчны шинжилгээ судалгааны институт
GSBPM	Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загвар
SDG	Тогтвортой хөгжлийн зорилго

НЭГ. МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН САЛБАРЫН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Үндэсний Статистикийн хороо 2019 онд статистикийн мэдээний чанарыг сайжруулах, хэрэглээ ашиглалтыг нэмэгдүүлэх, орон нутгийн статистикийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх хүрээнд 5 зорилго 22 зорилт бүхий үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг боловсруулан бүрэн хэрэгжүүлж ажиллалаа.

ҮСХ-ноос албан ёсны болон захиргааны мэдээллийг бодит байдалд нийцүүлэхээр 2019 онд чанарын хяналт шалгалтын ажлыг анхан шатны мэдээллийг биечлэн үзэж шалгах, мэдээллийн технологийг ашиглан мэдээллийг тулган шалгах болон тархааж буй мэдээлэлд хяналт мониторинг хийх гэсэн үндсэн 3 хэлбэрээр зохион байгуулав.

ҮСХ, яам, төрийн захиргааны бусад байгууллага болон тэдгээрийн салбар байгууллагын 21 аймаг, нийслэл, дүүргийн түвшинд ажиллаж байгаа Статистикийн улсын 108 байцаагчтай хамтран хэрэглээний үнэ, үйлдвэрлэгчийн үнэ, бизнес регистр болон эдийн засгийн салбаруудын мэдээлэл цуглуулалт, боловсруулалт, динамик бүрдүүлэлтийг 11 аймгийн статистикийн хэлтэст хянаж шалгасан. Мөн малын хагас жилийн түүвэр судалгааны хяналтыг 4 аймагт, жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллогын хяналтыг ХХААХҮЯ-тай хамтран 5 аймагт тус тус зохион байгуулсан. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, нийтлэг гарч байгаа алдаа, тулгарч буй асуудлыг тодорхойлж, холбогдох ажилтнуудад заавар, зөвлөмж, хугацаатай үүрэг даалгаврыг албан бичгээр хүргүүлж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллалаа.

ҮСХ-ноос төрийн захиргааны байгууллагуудын мэдээллийн сангийн уялдаа холбоог сайжруулж, зөрүүг арилгах ажлыг тогтмол хийж байна. Энэ ажлын үр дүнд статистикийн мэдээлэл цуглуулах шат дамжлага цөөрч, давхардалгүй болж, мэдээлэл боловсруулах хугацаа багасаж, хэрэглээ ашиглалт нэмэгдэж, мэдээллийн бодит байдал эрс сайжирч байна. Тухайлбал:

Хүн ам, өрхийн мэдээллийн сан (ХАӨМС), Бизнес регистрийн мэдээллийн сангийн

чанарыг сайжруулах зорилгоор холбогдох төрийн байгууллагуудын мэдээллийн сангуудтай тухай бүр тулгалт хийж, уялдуулан сайжруулах ажлыг зохион байгуулав.

Статистикийн салбарын хэмжээнд цуглуулж, нэгтгэн боловсруулж, тархааж байгаа статистикийн мэдээ, тайлан, эцсийн бүтээгдэхүүнд гарч буй алдааг илрүүлэх, баримтжуулах, залруулах, алдааны төрөл, шалтгаанд дүн шинжилгээ хийх, статистикийн чанарын шалгууруудыг бүрэн хэрэгжүүлэх зорилгоор “Статистикийн мэдээллийн алдааг илрүүлж, засвар, баримтжуулалт хийх журам”-ыг шинэчлэн боловсруулж, батлан мөрдөн ажиллаж байна.

ҮСХ-ноос монгол, англи хэлээр тархааж байгаа Монгол Улсын нийгэм эдийн засгийн байдлын сарын танилцуулга, Статистикийн жилийн эмхэтгэлд мэдээлэл боловсруулах явцад болон хэвлэлийн эх бэлтгэлийн дараа дунджаар 16 бүлгийн 138 хүснэгт, 15 хуудас мэдээлэлд байнгын хяналт тавьж ажиллав.

Статистикийн нэгдсэн мэдээллийн сан www.1212.mn-д байршуулсан 16 бүлгийн 330 хүснэгтийн мэдээллийг үзүүлэлт нэг бүрээр анхан шатны мэдээлэл, бусад эх үүсвэр, тооцоотой тулган шалгаж, илэрсэн алдаа, мэдээллийн зөрүүг арилгах ажлыг тухай бүрд нь шуурхай зохион байгуулан ажиллалаа.

Монгол Улс 2019 оны 4 дүгээр сарын 2-нд Олон улсын валютын сангийн мэдээлэл тархаалтын тусгай стандарт (SDDS)-д бүрэн шилжиж, уг стандартад шилжсэн дэлхийн 76 орны нэг болсон. Олон улсын валютын сангийн сайжруулсан мэдээлэл тархаах ерөнхий стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Монголбанк, Сангийн яамтай хамтран Үндэсний нэгдсэн мэдээллийн цахим санг байгуулж, нийгэм, эдийн засгийн 22 салбарын мэдээний баяжуулалтыг сар бүр шинэчлэн, салбаруудын мэдээллийг олон нийтэд тархааж байна.

Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn цахим хуудасны дизайн, бүтцийг ашиглахад илүү ойлгомжтой байдлаар шинэчлэв. Энэхүү мэдээллийн санд монгол, англи хэлээр 36 салбарын 774

статистик үзүүлэлтийг улс, бүс, аймаг, сум, багийн түвшинд 1921-2019 оноор бүрдүүлж, жил, улирал, сарын давтамжтай шинэчлэн баяжуулж байна. Цахим хуудасны файлын сан болон газарзүйн мэдээллийн санг тухай бүрд нь баяжуулж боловсронгуй болгосноор 2019 онд сайтын хандалтын тоо 1076.3 мянга болж, өнгөрсөн оныхоос 43.1 хувиар өссөн.

Олон нийтэд цахим уншлагын үйлчилгээ үзүүлэх зорилгоор <http://esan.mn> системтэй хамтран ажиллаж, ҮСХ-ноос 2019 онд бэлтгэн гаргасан 40 танилцуулга, судалгааны ажлыг хэрэглэгчид үнэгүй уншиж танилцах эрхтэйгээр, 2018 оны статистикийн эмхэтгэлийг нийлүүлж ажиллав.

Статистикийн байгууллагаас төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээгээр дамжуулан төрийн бусад байгууллагуудтай мэдээлэл солилцонажиллаж байна. Тооллого, судалгаа, мэдээлэл цуглуулах үйл ажиллагаанд зориулж 17 программ шинээр, 22 программд нэмэлт засвар өөрчлөлт хийсэн.

Нийгэм, эдийн засаг, байгаль орчны статистикийн олон улсад нийтлэг мөрдөгдөж буй арга зүйг судалж, үндэсний онцлогт тохируулсан арга зүйг боловсруулах ажлын хүрээнд нийт 6 аргачлал, 4 ангилал, 25 маягт, нөхөх зааврыг боловсруулж, шинээр болон шинэчлэн баталж мөрдүүлсэн байна.

Үндэсний статистикийн хороо 2019 онд Статистикийн тухай хуулийн дагуу албан ёсны статистикийн 48 багц үзүүлэлтийг тооцох мэдээллийг анхан шатны бүртгэл, захиргааны болон албан ёсны мэдээлэл мөн тооллого, түүвэр судалгаагаар долоо хоног, 14 хоног, сар, улирал, хагас жил, жилийн давтамжтай цуглуулав. Үүнд:

- ҮСХ-ноос 2019 онд зохион байгуулсан статистикийн улсын хэмжээний тооллого, түүвэр судалгаанд өрх, аж ахуйн нэгж, байгууллагыг бүрэн хамруулж, мэдээллийг хугацаанд нь цуглуулан боловсруулж, үр дүнг хэрэглэгчдэд хүргэв. Тухайлбал:
- Байшин, орон сууцны тооллогыг улсын хэмжээнд бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулж, тооллогын мэдээллийг хаягийн бүртгэлд суурилсан аргаар Collector for ArcGIS программ болон веб аппликэйшн ашиглан анх удаа зөөврийн төхөөрөмж (таблет)-өөр цуглуулсан.
- Дөрвөн жил тутам зохион байгуулдаг Цаг ашиглалтын 2019 оны судалгааны

мэдээлэл цуглуулалтыг анх удаа мобайл аппликэйшн ашиглан Булган, Говь-Алтай, Дорнод, Дундговь, Хэнтий, Хөвсгөл, Ховд, Төв аймаг болон нийслэлийн 9 дүүргийн 4000 өрхийг хамруулан зохион байгуулсан.

- НҮБ-ын Хүн амын сан, Оюу толгой ХХК-тай хамтран 2018 онд эхлүүлсэн Өмнөговь аймагт нийгэм, эдийн засаг, байгаль орчны судалгаа хийх төслийн үр дүнг танилцуулах тайлангийн хурлыг 2019 оны 9 дүгээр сард Өмнөговь аймгийн Даланзадгад хот, Ханбогд суманд зохион байгуулсан. Энэхүү судалгаа нь цаашид бусад аймагт жишиг болгон хэрэгжүүлэх загвар суурь судалгаа болох юм.

ҮСХ нь Статистикийн мэдээллийн нэгдсэн сангаас гадна албан ёсны статистикийн мэдээ, тооллого, судалгааны мэдээллийн үр дүнгээр Хүн ам, өрхийн мэдээллийн сан (ХАӨМС) болон Бизнес регистрийн мэдээллийн сан (БР)-г байгуулан олон улсын зөвлөмжид нийцүүлэн тоо мэдээллийн олон төрлийн эх үүсвэрээс тогтмол шинэчилж байна.

“Монгол Улсын Статистикийн жилийн эмхэтгэл-2018” номыг 2000-2006, 2016-2018 онуудыг харуулсан нийт 10 жилийн үзүүлэлтээр бэлтгэж, бүлэг бүрийн үзүүлэлтийг тооцох аргачлал, нэр томъёоны тайлбарыг оруулж, тухайн салбарын онцлох үзүүлэлтийг инфографикаар харуулсан байдлаар бэлтгэж УИХ, холбогдох яам, агентлаг, орон нутгийн статистикийн газар нэгж, олон улсын байгууллагуудад хүргүүлсэн.

Дэлхийн “Тогтвортой хөгжил 2030” хөтөлбөр, Монгол Улсын “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг дүгнэхэд шаардлагатай эдийн засаг, нийгэм, байгаль орчны үзүүлэлтийг тооцох, мэдээллийн эх үүсвэрийг бий болгох чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж, үндэсний болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Тухайлбал: Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлтийг тооцох боломжийг судлан мэдээллийн бэлэн байдлыг үнэлэхэд 2019 онд 14 үзүүлэлтээр өргөжүүлж, Монгол Улсад 244 шалгуур үзүүлэлтээс 132 үзүүлэлтийг тооцох болсон.

2019 оны 12 дугаар сарын байдлаар ТХЗ-

ын нийт 132 үзүүлэлтийг 2015-2018 оны гүйцэтгэлээр гаргаж хэрэгжилтийг хянах системд байршуулан, тухай бүрд баяжилтыг хийж, хэрэглэгчдэд тархааж ажиллалаа.

Монгол Улсын статистикийн салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зорилтын хүрээнд мэргэжлийн 4 шатлалт сургалтыг зохион байгуулж, статистикийн онол, нийгэм, эдийн засгийн салбарын статистик, эконометрик, статистикийн программ хангамж, үндэсний тооцоо, түүврийн дизайн, салбарын хууль, эрх зүйн мэдлэгийг олгож байна. Мэргэжлийн дөрвөн шатны сургалтад 2019 онд нийт 120 албан хаагч хамрагдсан байна.

Статистикийн мэргэжлийн мэдлэг, чадварыг ахиулах, бусад орны туршлагыг судлуулах зорилгоор статистикийн салбарын 146 ажилтныг (давхардсан тоогоор) олон улс болон бүс нутгийн хэмжээнд зохион байгуулагдсан 94 удаагийн сургалт, семинарт хамруулав.

Мөн “Төрийн албаны тухай” хуулийг шинэчлэгдсэнтэй холбоотой дагалдан гарах журмын хэрэгжилтийн хүрээнд Дорноговь, Өмнөговь, Дундговь, Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Сэлэнгэ, Булган, Хөвсгөл, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Архангай, Увс, Баян-Өлгий, Ховд (17) аймгуудын төрийн болон аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөл, сумдын статистикийн асуудал хариуцсан 3040 гаруй мэргэжилтнийг хамруулсан сургалтыг 2019 оны 6, 9 дүгээр саруудад зохион байгуулсан.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН СТАТИСТИКИЙН САЛБАРЫН 2019 ОНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

2.1 АЛБАН ЁСНЫ СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ

Үндэсний Статистикийн хороо 2019 онд Монгол Улсын Статистикийн тухай хууль, Статистикийн салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэхүйлажиллагааны төлөвлөгөөний дагуу албан ёсны статистикийн 48 багц үзүүлэлт (макро эдийн засгийн статистикийн 9, хүн ам, нийгмийн статистикийн 16, үйлдвэрлэл, шинжлэх ухаан, технологийн статистикийн 13, шүүхийн статистикийн 5, хүрээлэн байгаа орчны статистикийн 5)-ийг тооцох мэдээллийг анхан шатны бүртгэл, захиргааны болон албан ёсны мэдээ мөн тооллого, түүвэр судалгаагаар долоо хоног, 14 хоног, сар, улирал, хагас жил, жилийн давтамжтай цуглуулав. Тухайлбал:

- Аймаг, дүүрэг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрууд Үндэсний статистикийн хорооноос баталсан мэдээний хамрах хүрээ, маягт, нөхөх зааврын дагуу хүн ам, нийгэм, эдийн засгийн үйл ажиллагааны албан ёсны статистикийн 53 төрлийн мэдээг долоо хоног, 14 хоног, сар, улирал, хагас жил, жилийн давтамжаар өрх, аж ахуйн нэгж, байгууллагаас авч, графикт хугацаанд нь ирүүлсэн байна.
- Мөнгө, зээл, санхүү, гааль, даатгал, татвар, байгаль орчин, соёл, урлаг, боловсрол, шинжлэх ухаан техник, технологи, хүн амын эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хүнсний аюулгүй байдал, шүүхийн статистикийн мэдээллийг холбогдох яам, төрийн захиргааны нийт 27 байгууллага Үндэсний статистикийн хорооноос баталсан болон зөвшөөрсөн 206 маягтаар цуглуулан авч нэгтгэн сар, улирал, жилийн давтамжтай мэдээлсэн байна.
- Үндэсний Статистикийн хороо 2019 онд улсын хэмжээний 2 тооллого, 6 түүвэр судалгааг зохион байгуулж өрх, аж ахуйн нэгж, байгууллагыг бүрэн хамруулж, мэдээллийг хугацаанд нь цуглуулж, үр дүнг боловсруулав.

УСХ-нд хүн ам, өрх, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих мэдээллийн урсгалын дагуу төвлөрүүлэн авсан мэдээллийг бусад

мэдээллийн эх үүсвэртэй тулган шалгаж, боловсруулан статистикийн www.1212.mn мэдээллийн санг мэдээллийн давтамж бүрээр жилийн турш тогтмол шинэчлэн баяжуулж ажиллалаа.

Албан ёсны статистикийн мэдээллээр сар бүр Монгол Улсын нийгэм, эдийн засгийн танилцуулга, жил бүр Статистикийн өврийн дэвтэр болон Монгол Улсын статистикийн эмхэтгэлийг монгол, англи хэлээр, Хүн ам, нийгэм, эдийн засгийн статистикийн салбарын танилцуулгыг тус тус хэвлэн олон нийтэд хүргэн ажиллав.

2.1.1 ТООЛЛОГО

- Байшин, орон сууцны тооллого (БОСТ)-ыг улсын хэмжээнд бүсчилсэн хэлбэрээр 2019 оны 7 дугаар сарын 22-ноос 12 дугаар сарын 16-ны хооронд зохион байгуулсан. Энэ удаагийн тооллогын онцлог нь хаягийн зураг ашиглан байршилд суурилсан хэлбэрээр явуулсан явдал юм. 1960 оноос хойш анх удаа хийгдэж байгаа тооллогоор Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа бүх байшин, орон сууцны сан хөмрөгийг бүрэн тодорхойлох, орон сууцны фонд, хийц, ашиглалт, хүчин чадал, дэд бүтцийн хүртээмжийн талаар дэлгэрэнгүй мэдээллийн сантай болох зорилго тавьж ажилласан. Мөн тооллогод дэвшилтэт технологи болох мэдээлэл цуглуулах зөөврийн төхөөрөмж, мэдээлэл цуглуулалтын Collector for ArcGIS, Survey123 for ArcGIS программыг ашигласан. Тооллогын үр дүнг 2020 оны 1 сард явагдсан Хүн ам, орон сууцны тооллогын үр дүнтэй нэгтгэн тооцож нийтэд тархаана.
- Мал, тэжээвэр амьтдын болон хашаа худгийн 2019 оны жилийн эцсийн тооллогыг улс даяар 12 дугаар сард зохион байгуулж, дүнг баг, сум, аймгийн түвшинд хүлээн авч, нэгтгэлээ. Улсын дүнгээр нийт малын тоо 70.9 сая хүрч, өнгөрсөн оныхоос 6.8 хувиар өссөнөөс адуу 4.2 сая, үхэр 4.8 сая, тэмээ 472.4 мянга, хонь 32.3 сая, ямаа 29.3 сая тоологдсоныг олон нийтэд тархаалаа.

2.1.2 ТҮҮВЭР СУДАЛГАА

- Малын хагас жилийн түүвэр судалгааны мэдээлэл цуглуулалтыг батлагдсан түүврийнзагварын дагуу 2019 оны 6 дугаар сарын 4-нөөс 11-ний өдрүүдэд 21 аймаг, Улаанбаатар хотод зохион байгуулж, үр дүнг хүлээн авч шалган, боловсруулж, нэгтгэсэн. Түүвэр судалгааны үр дүнгээр бэлтгэсэн танилцуулгыг Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын 7 дугаар сарын танилцуулгад тусган олон нийтэд хүргэлээ. Энэхүү түүвэр судалгааны мэдээлэл нь даатгалын нөхөн төлбөр олгох суурь мэдээлэл болдог тул холбогдох хууль тогтоомжийн хүрээнд даатгалын компанид хүргүүлсэн.
- Томоохон аж ахуйн нэгжийн судалгааны мэдээллийг батлагдсан маягт, зааврын дагуу 1258 нэгжээс цуглуулж, боловсруулан бусад эх үүсвэрийн мэдээлэлтэй шалгаж, нэгдсэн үр дүнгийн тайланг боловсруулсан.
- Аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө, хөрөнгө оруулалтын улирлын судалгааг ДНБ-ий улирлын тооцоог хийх зорилгоор улирал бүр ААНБ-аас хөрөнгө, хөрөнгө оруулалтын мэдээллийг цуглуулав.
- Хэрэглээний бараа, үйлчилгээний 22 нэр төрлийн барааны үнийн мэдээг 7 хоног бүр 21 аймаг болон Улаанбаатар хотын дэлгүүр, цэгүүдээс цуглуулж, тархааж байна. Мөн гадаад худалдааны статистикийн экспортын 10, импортын 11 төрлийн гол нэрийн бүтээгдэхүүний мэдээг 15 хоног тутам гаргаж, олон нийтэд тархаасан.
- Хэрэглээний үнэ, үйлдвэрлэгчийн үнэ (аж үйлдвэр, тээвэр, мэдээлэл холбоо, худалдаа, зочид буудал, нийтийн хоол)-ийн судалгааг сар, улирал бүр зохион байгуулж, мэдээллийг цуглуулав.
- ҮСХ-ноос тогтмол зохион байгуулан явуулдаг “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-ны мэдээллийг сар бүр 21 аймаг, 9 дүүргийн нийт 1374 өрх, улиралд 4122 өрх, жилдээ 16488 өрхөөс цуглуулан авч, нэг өрхийн сарын дундаж орлого, зарлага, нэг хүнд сард ногдох бодит орлого, хэрэглээний тэнцүү 5 бүлэг, жини коэффициент, тейлийн индекс зэрэг үзүүлэлтүүдийг улирал, жилээр тооцон гаргаж нийтэд тархаасан.
- ҮСХ болон АХБ хамтран Монгол Улсын онцлогт тохирсон олон хэмжээст ядуурлын үзүүлэлтүүдийг тодорхойлох ажлын хүрээнд туршилтын судалгааг 6 аймагт зохион байгуулан явуулж, үр дүнг тооцон гаргасан. Мөн “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-ны 2010, 2014, 2018 оны мэдээллийг ашиглан олон хэмжээст ядуурлын индексийг гурван хувилбараар тооцон гаргасан.
- Ажиллах хүчний судалгаанд жилдээ 13920 өрх хамрагддаг бөгөөд мэдээллийг сар бүр цуглуулж, үр дүнг улирал, жилээр тархааж байна. Энэ судалгаагаар хүн амын хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн талаарх мэдээллийг улсын хэмжээнд болон бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшинд гаргадаг.
- Дөрвөн жил тутам зохион байгуулдаг Цаг ашиглалтын 2019 оны судалгааны мэдээлэл цуглуулалтыг анх удаа мобайл аппликэйшн ашиглан Булган, Говь-Алтай, Дорнод, Дундговь, Хэнтий, Хөвсгөл, Ховд, Төв аймаг болон нийслэлийн 9 дүүргийн 4000 өрхийг хамруулан зохион байгууллаа. Тус судалгаа нь хүн амын эрхэлж байгаа үйл ажиллагааг тодорхойлж, тэдгээрт зарцуулж буй цагийг хэмжих бөгөөд хөлстэй болон хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй цагийг хүйсээр гаргаж, хүн амын амьдралын хэв маягийг тодорхойлох, түүнд гарч байгаа өөрчлөлтийг судлах зорилготой юм. Уг судалгааг зохион байгуулснаар хүн амын амьдралын хэв маяг, амьдралын чанарын талаарх мэдээлэл, дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний хангамж, хүртээмжийг сайжруулах, хөрөнгө оруулалт хийх бодлого хөтөлбөр боловсруулах мэдээллүүдийг бий болгож, Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг хянах, Үндэсний тооцооны данснуудтай зэрэгцүүлэн байгуулдаг туслах дансны тооцоонд хөлсгүй хөдөлмөрийн талаарх мэдээллийг оруулах боломжийг бүрдүүлсэн.
- Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааг 5 жил тутам Тогтвортой хөгжлийн зорилт, Хүүхдийн эрхийн конвенц, Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц тунхаглал, НҮБ-ын ерөнхий Ассамблейн ХДХВ/ДОХ-ын асуудлаар тусгай чуулганы тунхаглал болон үндэсний (Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах

бодлого, Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр, Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр зэрэг) хэмжээний бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтийн тоо мэдээллийн санг бүрдүүлэх үндсэн зорилготой зохион байгуулдаг.

- Тайлант хугацаанд 2018 онд зохион байгуулсан судалгааны үр дүнгийн тооцооллыг хийж, НҮБ-ын Хүүхдийн сангийн олон улсын судалгааны төв багт танилцуулсан.
- Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны тайланг монгол, англи хэлээр боловсруулан хэвлүүлж, үр дүнг танилцуулах семинарыг 300 хүнийг хамруулан зохион байгуулав.

2.1.3 СТАТИСТИКИЙН НЭМЭЛТ МЭДЭЭ

ҮСХ-ны даргын 2018 оны А/159 тоот тушаалаар баталсан “ҮСХ-нд нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтсээс 2019 онд цахим шуудангаар ирүүлэх мэдээ, тайлангийн график” болон “ҮСХ-нд яам, газруудаас 2019 онд ирүүлэх мэдээ тайлангийн график”-ын дагуу дээр дурдсан албан ёсны статистикийн мэдээллээс гадна 2019 онд дараах мэдээ, түүвэр судалгааны мэдээллийг цуглуулж, үр дүнг боловсруулсан. Үүнд:

- Дэлхийн 190 гаруй улс орныг хамарсан “Олон улсын өртгийн зэрэгцүүлэлт 2017” хөтөлбөрийн хүрээнд 2017 оны судалгааны өрхийн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ, орон сууцны түрээсийн үнэ, төрийн албан хаагчийн цалин, орон сууцны талаарх мэдээлэл, ДНБ-ий эцсийн ашиглалтын тооцооны 2017 оны эцсийн гүйцэтгэл, 2018 оны урьдчилсан гүйцэтгэлийн тооцоог 155 бараа, үйлчилгээний түвшинд, 2011-2018 оны мэдээллийг оны болон зэрэгцүүлэх үнээр 27 бүлгийн түвшинд гарган Азийн хөгжлийн банкинд хүргүүлсэн. Орон сууцны тоо, хэмжээ болон нөхцөлийн талаарх мэдээллийг АХБ-наас ирүүлсэн асуулга, маягтын дагуу хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллогын мэдээлэлд үндэслэн засварлаж, үр дүнг АХБ-нд хүргүүлэв. Тус хөтөлбөрийг 2020 онд хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд өрхийн хэрэглээний бараа, үйлчилгээ, барилгын материал, машин тоног

төхөөрөмжийн жагсаалтыг хянан, үнэ цуглуулах боломж, хамралтын хүрээ, давтамжийн талаарх саналаа АХБ-нд хүргүүлсэн.

- Барилга, байгууламжийн өртгийн индекс тооцох, ДНБ-ийг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэх тооцоонд ашиглах, барилгын салбарын өртгийн болон үнийн өсөлтийг харьцуулах зорилгоор Барилгын өртгийн индекс тооцох судалгааг явуулав. Улирал бүр 21 аймаг, нийслэлийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт барилга угсралтын ажил гүйцэтгэж буй ААНБ-аас мэдээллийг цуглуулсан.
- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Малын генетик, нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор малын бүртгэлийн мэдээллийн санг сайжруулах, шинээр маягт, заавар боловсруулах, малчин өрхийн мэдээллийн сангийн мэдээг тулган нягтлах, мэдээллийг төрийн мэдээлэл солилцооны “Хур” системд холбохоор ХХААХҮЯ-тай хамтран ажиллаж байна. Малын генетик нөөцийн бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, тайлагнах журмыг ХХААХҮЯ-тай хамтран баталсан. Мөн Мал эмнэлгийн ерөнхий газрын “Үндэсний мал эмнэлгийн гэрчилгээний систем”-ийн үйл ажиллагаанд мал тооллогын мэдээллийн санг ашиглах тухай гэрээ байгуулж, хамтран ажилласан.
- Ардчилсан засаглал судалгааны мэдээллийг улирал бүр 15 ба түүнээс дээш насны 638 хүнээс, жилдээ 2552 хүнээс цуглуулан авч, мэдээллийг бүтэн жилээр нэгтгэн үр дүнг тооцон гаргаж, 2018 оны тайланг бичиж тархаасан.
- Хэрэглэгчийн төлөв байдлыг тодорхойлох судалгааны мэдээллийг улирал бүр 18 ба түүнээс дээш насны 638 хүнээс, жилдээ 2552 хүнээс цуглуулан, 2018 оны судалгааны мэдээллийг нэгтгэн үр дүнг тооцон гаргаж, тайланг Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт хүргүүлж хэрэглэгчдэд тархаасан.
- Өрхийн амьжиргаанд сөргөөр нөлөөлөх гэнэтийн хүндрэл бэрхшээлийн судалгааны мэдээллийн баазыг бүрдүүлж үр дүн, уялдаа холбооны шалгалтыг хийж эцэслэн Дэлхийн банкинд хүргүүлсэн.
- ҮСХ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон 11 байгууллагын төлөөлөл

бүхий 22 гишүүнтэй ажлын хэсэг хамтарч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх мэдээллийн сан байгуулах ажлыг зохион байгуулав.

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх анхдагч мэдээллийн санг бий болгох зорилгоор Хөгжлийн бэрхшээлийн дэд мэдээллийн санг байгуулах, үзлэг тооллогыг явуулах бэлтгэл ажлын хүрээнд Баян-Өлгий, Ховд аймагт туршилтын судалгааг зохион байгуулж, үр дүнг ажлын хэсэгт танилцуулсан.
- Жендэрийн статистикийг бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаанд ашиглах аргачлал боловсруулж, хуулиар үүрэг хүлээгчдэд хүргүүлэх, жендэрийн статистикийг нэгтгэн боловсруулах программ хангамжийг нэвтрүүлэх, мэдээллийн санг бүрдүүлэхээр Жендэрийн үндэсний хороотой хамтран ажиллаж байна.
- НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгын холбогдох үзүүлэлтүүдийг дүгнэхэд шаардлагатай мэдээллийг гаргах, хуульчдын талаарх албан ёсны мэдээлэлтэй болох зорилгоор Монголын Хуульчдын холбоотой хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд Хуульчдын нэгдсэн бүртгэлийн маягт, түүнийг нөхөх зааврыг шинээр боловсруулан баталж, хуульчдын талаарх нэгдсэн мэдээллийг жилийн эцсийн байдлаар гаргаж тархааж эхэлсэн.
- Малчин өрхийн амьдралын хэв маяг тодорхойлох зорилготой Нүүдэлчин өрхийн туршилтын судалгааг анх удаа газар зүйн мэдээллийн систем ашиглан боловсруулж, судалгааны түүврийн загварын дагуу Булган аймгийн Баян-Агт, Сайхан, Могод, Гурванбулаг сумдын 483 өрхийг хамруулан явууллаа.
- Хүн ам, орон сууцны 2020 оны тооллого явуулах бэлтгэл ажлын хүрээнд Тооллогын нарийвчилсан төлөвлөгөө, төсвийг батлуулан, тооллогыг бүртгэлд суурилсан аргаар явуулах тооллогын нэгжийн хүрээг тодорхойлж, холбогдох 4 байгууллагын мэдээллийн эх үүсвэр, үзүүлэлтийн бэлэн байдлыг тодорхойлж, туршилтын тооллогыг Нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн 3 хороо, Дорнод аймгийн Хэрлэн сумын 3 багт 2019 оны 1 дүгээр сарын 10-16-ны хооронд зохион байгууллаа. Хүн ам, орон сууцны ээлжит тооллогын бэлтгэлийг бүрэн хангаж, тооллогыг 2020 оны 1 дүгээр сарын 8-наас 9-нд шилжих шөнийн 00:00 цагаас эхлэн 7 хоногийн турш явуулах товыг тогтлоо.
- НҮБ-ын Хүн амын сан, Оюу толгой ХХК-тай хамтран Өмнөговь аймагт нийгэм, эдийн засаг, байгаль орчны судалгаа хийх төслийг 2018 онд хэрэгжүүлж эхэлсэн юм. Судалгааны үр дүнг танилцуулах ажлыг 2019 оны 9 дүгээр сард Өмнөговь аймгийн Даланзадгад хот, Ханбогд суманд зохион байгуулж, холбогдох мэдээллийг тархаасан. Энэхүү төсөл нь статистикийн мэдээлэлд тулгуурлан үнэлгээ дүгнэлт хийх, нотолгоонд суурилсан бодлогын зөвлөмж гаргах зорилготой юм. Төслийн үр дүнд Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны загвар суурь судалгааг гаргасан бөгөөд уг төслийг цаашид бусад аймагт жишиг болгон хэрэгжүүлэх юм.
- НҮБ-ын Хүн амын сангийн хүсэлтээр Өмнөговь аймгийн Ханбогд, Номгон сумдад “Залуучуудын хөгжил болон өсвөр насны охид, эмэгтэйчүүдийн жирэмслэлт, төрөлтийн байдал” судалгааг зохион байгуулж, судалгааны мэдээллийг нэгтгэн боловсруулж, “Залуучуудын хөгжил” болон “Өсвөр насны охидын эрт жирэмслэлт, төрөлт” тайланг гаргаж, НҮБ-ын Хүн амын санд хүлээлгэн өгсөн.
- НҮБ-ын Хүн амын сангийн захиалгаар Монгол Улсад 2016-2020 онд хэрэгжиж буй “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь” төслийг үнэлэх зорилгоор Нэг цэгийн үйлчилгээний төв болон Олон нийтийн мэдлэг, хандлага, ойлголтыг үнэлэх судалгааг зохион байгуулж, улсын хэмжээнд 5000 иргэнийг хамруулсан.
- ХБНГУ-ын Эдийн засгийн судалгааны институттэй 2020 онд хамтран зохион байгуулах Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход өрхөд үзүүлэх дэмжлэг өрхийн панел судалгаа болон Ажилгүйдэл, бүрэн бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааны бэлтгэлийг ханган ажиллалаа.

2.1.4 МЭДЭЭЛЛИЙН САН

ҮСХ нь албан ёсны статистикийн мэдээ, тооллого, судалгааны мэдээллийн үр дүнгээр статистикийн “Хүн ам, өрхийн мэдээллийн сан” болон “Бизнес регистрийн мэдээллийн сан”-г шинэчлэн ажилладаг. Эдгээр мэдээллийн сан нь хүн ам, өрх, нийгэм, эдийн засгийн статистикийн мэдээлэл цуглуулах түүврийн үндсэн хүрээ болж ашиглагддаг.

“Хүн ам, өрхийн мэдээллийн сан” болон “Бизнес регистрийн мэдээллийн сан” нь статистикийн мэдээллийн уялдаа холбоо, чанарт шууд нөлөөлдөг тул олон улсын зөвлөмжид нийцүүлэн тоо мэдээллийн олон төрлийн эх үүсвэрээс тогтмол шинэчлэх ажлыг зохион байгуулан ажиллалаа.

2.2 ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дэлхийн “Тогтвортой хөгжил 2030” хөтөлбөр, Монгол Улсын “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг дүгнэхэд шаардлагатай эдийн засаг, нийгэм, байгаль орчны үзүүлэлтийг тооцох, мэдээллийн эх үүсвэрийг бий болгох чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж, үндэсний болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлтийг тооцох боломжийг судлан мэдээллийн бэлэн байдлыг үнэлэхэд 2019 онд 14 үзүүлэлтээр өргөжүүлж, Монгол Улсад 244 шалгуур үзүүлэлтээс 132 үзүүлэлтийг тооцох болов. (Хавсралт хүснэгт 1, 2)

Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилгын шалгуур үзүүлэлтүүдийн мэдээллийн сан (UN Global SDG Database)-д тавигдсан Монгол Улсын үзүүлэлтүүд болон үндэсний хэмжээнд мэдээлсэн тоон үзүүлэлтүүдийн зөрүүтэй байдлын үнэлгээг хийлээ.

ҮСХ-ноос мэдээллийн зөрүүтэй байдлыг арилгах талаар үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллалаа. Тухайлбал:

- НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгын тоон мэдээллийн нэгдсэн систем (Federated Information System)-д холбогдох ажлыг эхлүүлж, НҮБ-ын Статистикийн хэлтэс, Байгаль орчны шинжилгээ судалгааны институт (ESRI)-

тэй хамтран ТХЗ-ын үзүүлэлтийг аймгийн түвшинд нарийвчлан гаргаж, холбогдох тоо мэдээллийг системд оруулахаар ажиллаж байна.

- Ногоон хөгжлийн үндсэн 38 үзүүлэлтээс Монгол Улсад гарч байгаа 33 үзүүлэлтийг 2018 оны байдлаар тооцож, динамикийг шинэчилж, статистикийн мэдээллийн санг баяжуулсан. Байгаль орчны статистикийн мэдээллийн шинэчилсэн маягтад ТХЗ болон ногоон хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдээс шинээр болон шинэчлэн тооцох үзүүлэлтүүдийг тусгасан.
- ТХЗ-ын одоогоор тооцох боломжгүй байгаа 6 үзүүлэлтүүдийг Авлигатай тэмцэх газрын захиргааны статистикийн мэдээний болон барилга, мал, тэжээвэр амьтдын тооллого, өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны маягт, асуулгад тус тус тусгуулав. Тухайлбал,
- Барилгын салбарын статистикийн үзүүлэлт тооцох аргачлалд 11.7.1, Авлигатай тэмцэх газрын захиргааны маягтад 16.5.1, 16.5.2, Мал аж ахуйн захиргааны статистикийн мэдээний маягтад 2.5.1, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны асуулгад 1.4.1, 2.1.2 үзүүлэлтийг тус тус тусгаж, холбогдох тоо мэдээллийг цуглуулж үзүүлэлтийг тооцох боломжийг бүрдүүлэв.
- Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр “Тогтвортой хөгжлийн зорилгуудын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийхэд мэдээллийн олон эх үүсвэрийг ашиглах нь” төслийг 2018 оны 7 дугаар сараас эхлэн хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд холбогдох 30 үзүүлэлтийн мэдээллийн эх үүсвэрийг тодорхойлж, аргачлал арга зүйг боловсронгуй болгох, тоо мэдээллийг тооцох, сайжруулах, уламжлалт бус мэдээллийн эх үүсвэрийг ашиглах талаар “Ядуурал, хүн ам, нийгмийн хамгаалал”, “Хүнс тэжээл, хөдөө аж ахуй”, “Боловсрол”, “Харилцаа холбоо, дэд бүтэц”, “Эдийн засаг, байгаль орчин” гэсэн 5 ажлын хэсгийг холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулсан. Мөн жендэр, боловсрол, нийгмийн хамгааллын асуудлаар үндэсний зөвлөхүүдтэй, олон хэмжээст ядуурлын чиглэлээр олон улсын зөвлөхтэй хамтран ажиллав. Төслийн

дунд хугацааны тайлангийн хурлыг холбогдох яам, төрийн байгууллагуудын 47 төлөөллийг хамруулан зохион байгуулав.

- Тогтвортой хөгжлийн зорилгын талаар мэдлэг, мэдээлэл өгөх, сурталчлан таниулах, хэрэгжилтийг хянах, үнэлэх зорилго бүхий хяналтын систем (dashboard)-ийг байгуулж, 2019 оны 9 дүгээр сараас ажиллуулж байна. Тус системийг хэрэглэгчдэд ашиглахад хялбар, ойлгомжтой байхаар сайжруулах, тоо мэдээллийг төрийн байгууллагуудаас цуглуулж нэгтгэх, тоо мэдээллээр баяжуулах ажлыг тогтмол хийж байна. ТХЗ-ын хэрэгжилтийг хянах системийг бүрэн ажиллуулснаар үндэсний ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийн тоо мэдээллийг нэгдсэн байдлаар цуглуулах, тооцох, үзүүлэлтүүд зорилтот түвшиндээ хүрч байгаа эсэхийг үнэлж дүгнэх, хэрэгжилтийг тайлагнах боломж бүрдэх юм.
- 2019 оны 12 дугаар сарын байдлаар ТХЗ-ын нийт 132 үзүүлэлтийг 2015-2018 оны гүйцэтгэлээр гаргаж хэрэгжилтийг хянах системд байршуулан, тухай бүрт баяжилтыг хийж, хэрэглэгчдэд тархааж байна.

2.3 АНХАН ШАТНЫ МЭДЭЭНИЙ ЧАНАР, ШУУРХАЙ БАЙДЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ

ҮСХ-ноос статистикийн үйл ажиллагааны бүх үе шатанд (түүвэр судалгааны төлөвлөлт болон судалгааны зохиомж дизайн, мэдээлэл цуглуулалт, боловсруулалт, дүн шинжилгээ, тархаалт) дараах чиглэлээр чанарын хяналтыг тухай бүрд нь тогтмол хийж байна. Тухайлбал статистикийн мэдээлэл нь:

- Хэрэглэгчдийн хэрэгцээг хангаж байгаа байдал;
- Мэдээ болон статистикийн тооцоолол нь зөв, бодит байдалд нийцсэн эсэх, мэдээллийн бусад эх үүсвэрүүдтэй уялдсан байдал;
- Мэдээллийг тодорхой, ойлгомжтой график болон зургаар харуулах зэргээр мэдээлэл танилцуулах аргыг ашиглаж боловсруулсан эсэх;
- Мэдээлэл нь цаг хугацаагаар, бүс нутгаар болон улс орнуудаар, мөн ижил

үзүүлэлтээр харьцуулах боломжтой, уялдаатай байгаа эсэх, статистикийн өөр өөр салбарт хэрэглэх боломжтой байх;

- Мэдээлэл нь дагалдах хангалттай болон оновчтой мета мэдээлэлтэй байгаа эсэх, мэдээллийн чанарын талаарх мэдээлэл байгаа эсэх;
- Мэдээллийг шуурхай боловсруулж, цаг хугацаанд нь нийтэд тархаасан байдал;
- Хэрэглэгчид мэдээллийг хүртээмжтэй, хялбар аргаар авч буй биет нөхцөл байдал зэрэг болно.

Статистикийн тухай хууль, статистикийн чанарын удирдлагын зарчмуудыг хэрэгжүүлэх хүрээнд Үндэсний Статистикийн хороонд нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтэс болон яам, газруудаас 2020 онд ирүүлэх албан ёсны болон захиргааны статистикийн мэдээ, тайлангийн жагсаалт, графикт хугацааг боловсруулан ҮСХ-ны даргын 2019 оны А/198 тоот тушаалаар батлав.

ҮСХ-ноос баталсан “Хэрэглэгчийн болон үйлдвэрлэгчийн чанарын тайланг боловсруулах журам”-ын дагуу материалын урсгалын, байгаль орчны татварын, эрчим хүчний биет урсгалын дансаар хэрэглэгчдэд болон үйлдвэрлэгчдэд зориулсан статистикийн чанарын 6 тайланг бэлтгэн, статистикийн мэдээллийн цахим хуудаст байршуулж нийтэд тархаасан.

ҮСХ-ноос албан ёсны болон захиргааны мэдээллийг бодит байдалд нийцүүлэхээр 2019 онд чанарын хяналт шалгалтын ажлыг анхан шатны мэдээллийг биечлэн үзэж шалгах, мэдээллийн технологийг ашиглан мэдээллийг тулган шалгах болон тархааж буй мэдээлэлд хяналт мониторинг хийх гэсэн үндсэн 3 хэлбэрээр зохион байгуулав.

2.3.1 СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ БИЕЧЛЭН ҮЗЭЖ ШАЛГАСАН БАЙДАЛ

Статистикийн мэдээллийн бодит байдалд нийцэж буйг мэдээллийн урсгалын дагуу шалгах ажлыг ҮСХ, яам, төрийн захиргааны бусад байгууллага болон тэдгээрийн салбар байгууллагын 21 аймаг (79), нийслэл хот (15), дүүргийн (14) түвшинд ажиллаж байгаа Статистикийн улсын 108 байцаагчтай хамтран хэрэгжүүлсэн. Тухайлбал:

- Хэрэглээний үнэ, үйлдвэрлэгчийн үнэ,

бизнес регистр болон эдийн засгийн салбаруудын мэдээлэл цуглуулалт, боловсруулалт, динамик бүрдүүлэлтийг Булган, Сэлэнгэ, Хөвсгөл, Өвөрхангай, Говь-Алтай, Дорнод, Өмнөговь, Завхан, Ховд, Дорноговь, Баянхонгор аймгийн статистикийн хэлтэст хянаж шалгасан.

- Эдийн засаг, үнийн статистик, бизнес регистрийн мэдээ тайланг цуглуулах, нэгтгэх, боловсруулах, тархаах явцад өөрийн үнэлгээний судалгааг хариуцсан ажилтнууд хийж, үр дүнг гарган цаашид анхаарах асуудлуудыг тодорхойлов. Сар, улирлын мэдээ, тайланд гарсан алдаа, түүнд хийсэн залруулга, хийгдсэн засвар, өөрчлөлт зэргийг багтаасан эдийн засаг, үнэ, бизнес регистрийн үйлдвэрлэгчийн тайлан, сар, улирал, жилийн мэдээний баримтжуулалтыг хийсэн.
- Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, нийтлэг гарч байгаа алдаа, тулгарч буй асуудлыг тодорхойлж, холбогдох ажилтнуудад заавар, зөвлөмж өгч, хугацаатай үүрэг даалгаврыг байгууллагын эрх баригчид албан бичгээр өгч, биелэлтэд хяналт тавьж ажиллалаа.
- БСШУСЯ, ЭМЯ-тай хамтран хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хүрээнд хамтран баталсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу 10 аймгийн 96 сум, 547 баг, 766 байгууллагад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг БСШУС-ын сайд, Эрүүл мэндийн сайдад хүргүүлээ.
- Малын хагас жилийн түүвэр судалгааны хяналтыг Өмнөговь, Дорноговь, Хөвсгөл, Архангай аймагт зохион байгуулсан.
- Жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллогын хяналтын ажлыг ХХААХҮЯ-тай хамтран Төв, Говьсүмбэр, Хөвсгөл, Өвөрхангай, Баян-Өлгий аймагт зохион байгуулсан.
- Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын захиргааны болон албан ёсны статистикийн мэдээллийн чанар, хамралтыг сайжруулах ажлыг баталсан удирдамжийн дагуу гүйцэтгэсэн. Дээрх 2 байгууллагад мэдээ, тайлангийн хамралтыг нэмэгдүүлэх, анхдагч мэдээллийн чанарыг хангаж үнэн зөв гаргах, хэт өндөр, хэт бага утгуудад албан

ёсны тайлбарыг заавал хийх, аливаа алдаа, засвар, залруулгыг баримтжуулж хэвших, статистикийн мэдээллийн ашиглалт, хэрэглээг нэмэгдүүлэх талаар хугацаатай үүрэг өгч хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа.

- Монгол Улсын Статистикийн тухай хуулийн дагуу Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны А/56 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан шинэ ажлын байрны захиргааны статистикийн мэдээний бүртгэл, хамралт, мэдээний урсгал, нэгтгэлийн үйл явцад хяналт, шинжилгээ хийж ажилласан. Хяналтыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газартай хамтран Хан-Уул дүүрэг, Төв аймгийн Сэргэлэн, Зуунмод суманд хийсэн.
- Албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийн хяналтыг сайжруулахад статистикийн салбарт ажиллаж буй ажилтнуудын чанарын удирдлагын талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэхэд мэргэжлийн туслалцаа үзүүлж ажилласан.
- Ялангуяа мэдээллийн урсгалыг оновчтой болгох, энэ урсгалын шат бүрд статистикийн бүртгэл, мэдээллийн чанарт тавих дотоод хяналтыг сайжруулах, бусад мэдээллийн эх үүсвэрүүдтэй уялдуулах, мэдээллийн сан байгуулах талаар БОАЖЯ, ЗТХЯ, ХНХЯ, ЭМЯ, БСШУСЯ зэрэг яам, төрийн захиргааны байгууллагуудын статистикийн мэдээлэл хариуцсан нэгж, ажилтнуудтай уулзалт ярилцлага зохион байгуулж, зөвлөгөө өгсөн.

2.3.2 МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙГ АШИГЛАН МЭДЭЭЛЛИЙГ ШАЛГАСАН БАЙДАЛ

ҮСХ-ноос мэдээллийн технологийг ашиглан төрийн захиргааны байгууллагуудын мэдээллийн сангийн уялдаа холбоог сайжруулж, зөрүүг арилгах ажлыг зохион байгуулсан. Энэ ажлын үр дүнд статистикийн мэдээлэл цуглуулах шат дамжлага цөөрч, давхардалгүй болж, мэдээлэл боловсруулах хугацаа багасаж, хэрэглээ ашиглалт нэмэгдэж, мэдээллийн бодит байдал эрс сайжирч байна. Тухайлбал:

- Салбаруудын мэдээллийн санг Нийгмийн

даатгалын ерөнхий газрын мэдээллийн сантай уялдуулах ажлын хүрээнд бизнес регистрийн санг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даатгал төлөгч аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн мэдээллийн сантай холбосон.

- Үндэсний дата төвийн Нэгдсэн нэвтрэлтийн систем буюу ДАН системийг ашиглан тоон гарын үсэг, гар утасны дугаар, үндэсний цахим шуудангаар дамжуулан систем хөгжүүлэх техникийн тохиргоо, дэд кодчиллыг хийсэн.
 - Дотоод худалдааны улирлын мэдээ болон хэрэглээний үнийн мэдээг Татварын ерөнхий газрын захиргааны статистикийн мэдээллээр сар бүр гаргах шийдлийг бий болгох хүрээнд тус газраас НӨАТ-ын мэдээллийг авч үр дүнг нэгтгэж, туршилтын тооцоог хийсэн.
 - Эдийн засгийн салбаруудын статистикийн мэдээлэл, бизнес регистрийн сан, үнийн статистик мэдээллийг Татварын ерөнхий газар, Гааль, татварын статистикийн мэдээллийн төвийн Нэмэгдсэн өртгийн албан татварын цахим төлбөрийн баримттай уялдуулахаар ажиллаж байна.
 - ҮСХ, Эрүүл мэндийн яам, Улсын бүртгэлийн ерөнхий газар хамтран шинээр төрсөн хүүхдийг 2018 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн нийслэлийн бүх шатлалын эмнэлэгт, 2019 оны 1 дүгээр сарын 1-нээс аймгийн төрөх эмнэлэгт цахимаар бүртгэж эхэлсэн нь Эрүүл мэндийн яамны бүртгэл болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын төрөлт, нас баралтын бүртгэлийн дунд нэг ч иргэн орхигдохгүй байх боломжийг бүрдүүлсэн. Ингэснээр хүн ам зүйн үндсэн үзүүлэлтээр гаргаж буй эрүүл мэндийн статистикийн үзүүлэлтийг өрхийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлттэй холбох, хүн амын ердийн хөдөлгөөний талаарх тоо мэдээг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангаас гаргаж, олон улсын жишигт нийцсэн статистикийг шинээр бий болгох, төрийн байгууллагуудын мэдээллийн сангийн уялдаа холбоог сайжруулах, мэдээлэл харилцан солилцох, бүртгэлийн үнэн зөв байдлыг хангах нөхцөл бүрдсэн.
 - Монгол Улсын Эрүүгийн хуулийн шинэчлэлтэй холбогдуулан гэмт хэргийн төрөлд орсон өөрчлөлтийг статистикийн холбогдох үзүүлэлт, динамикт тусган
- засварлаж, статистикийн нэгдсэн мэдээллийн сан www.1212.mn-ыг 2000-2018 оны мэдээллээр баяжуулсан. Open data watch-ийн шалгуурын дагуу Meta мэдээллийн санд аргачлал, ойлголт, тодорхойлолтыг монгол, англи хэлээр оруулав.
 - Open data watch-ийн шалгуурын хүрээнд хохирогч иргэд, гэмт хэрэг үйлдэгч иргэдийн тоог гэмт хэргийн төрлөөр, насны ангиллаар, 2007-2018 оноор бэлтгэн оруулав.
 - Статистикийн нэгдсэн мэдээллийн сан www.1212.mn-т “Хуульчдын нэгдсэн сан”-гийн мэдээллийг шинээр англи, монгол хэлээр бэлтгэн оруулав.
 - Хөдөлмөрийн статистикийг ажиллах хүчний судалгааны үр дүнгээр, төрийн албан хаагчдын, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын, хөдөлмөрийн хамтын маргааны, хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй гадаад иргэдийн, бүртгэлтэй ажилгүй иргэдийн мэдээний 2018 оны жилийн эцэс болон 2019 оны сар, улирлын мэдээллээр тухай бүр баяжуулсан.
 - Хүн ам, өрхийн мэдээллийн сан (ХАӨМС)-гийн чанарыг сайжруулах зорилгоор 2019 онд БСШУСЯ, ЗТХЯ, НХЕГ зэрэг бусад төрийн байгууллагын мэдээллийн сантай уялдуулж, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад суралцагчид, халамжийн, хүүхдийн асрамжийн, тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийн зөрүүг арилгаж, баяжилтыг сайжруулав.
 - ХАӨМС-ийн мэдээллийг иргэн өөрөө шалгах registration.nso.mn системийг хөгжүүлж ашигласнаар мэдээллийн сангийн бодит байдал эрс дээшлэв.
 - Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын хүрээнд “Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтэр” (ХАӨБД)-ийг тооллогоор цуглуулах нэмэлт үзүүлэлтээр шинэчилсэн. Тооллогын бэлтгэл үе шат буюу 2019 оны турш шинэчилсэн ХАӨБД-ийн дагуу засаг захиргааны анхан шатны нэгж буюу баг, хороодын ажилтнууд өөрийн нутаг дэвсгэрийн өрх бүрээр орж бүртгэлийг хөтөлж, ХАӨМС-ийн мэдээллийг баяжуулан сайжруулсан.
 - УБЕГ, ГХЯ, ЭМЯ, Эрүүл мэндийн хөгжлийн

үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төв, ЦЕГ, ХНХЯ, НДЕГ, Авто тээврийн үндэсний төв, Мал, тэжээвэр амьтдын тооллого, БСШУСЯ-ны ЕБС, СӨБ, дээд боловсрол эзэмшигчдийн сан, Хил хамгаалах ерөнхий газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар, ШШГЕГ, Барилгын хөгжлийн төв, ГИХГ, ТАЗ, БХЯ-ны мэдээллийн сангуудтай тухай бүр тулгалт хийж, уялдуулан ХАӨМС-г сайжруулсан.

- Бизнес регистрийн мэдээллийн санг тогтмол шинэчлэн баяжуулж, төрийн зарим байгууллагуудын мэдээллийн сантай уялдуулан мэдээллийн зөрүүг арилгасан. Тухайлбал:
- ✓ 2019 онд шинээр байгуулагдсан 18.6 мянган ААНБ-аас 14 хоногийн мэдээг авч, шалгаж, баталгаажуулан бизнес регистрийн санд нэмсэн.
- ✓ Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газарт бүртгэлтэй 55.0 мянган ААНБ-ын мэдээллийг бизнес регистрийн сантай тулгаж, уялдуулсан.
- ✓ Эрүүл мэндийн хөгжлийн төвд бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулж байгаа 4.9 мянган эмнэлэг, сувилал, эмийн сан, эм хангамжийн газрын мэдээллийг шалгаж, өөрчлөлт, хөдөлгөөнийг бизнес регистрийн санд тусгасан.
- ✓ Хоршооны эдийн засгийн үзүүлэлтүүдийг 4474 нэгжээс тодруулан, бизнес регистрийн санд засварласан.
- ✓ Татварын ерөнхий газрын ААНОАТ-ын 2018 оны жилийн эцсийн тайланд хамрагдсан 100.9 мянган аж ахуйн нэгжийг бизнес регистрийн сантай тулгаж, бүртгэгдээгүй байсан 1036 нэгжийг нэмж, 100.5 мянган нэгжийн борлуулалтын орлогын мэдээллийг бизнес регистрийн санд шинэчилсэн.
- ✓ Татварын ерөнхий газрын ААНОАТ-ын 2019 оны 1-3 дугаар улирлын тайланд хамрагдсан боловч бизнес регистрийн санд регистрийн дугаараар олдохгүй байгаа 2179 нэгжийг бизнес регистрийн санд шалгаж, аж ахуйн нэгжээс мэдээллийг тодруулж, регистрийн санд нэмж оруулсан.

- ✓ Бизнес регистрийн мэдээллийн санг 1998-2004 оны 20 улирлын нийт 649524 бичлэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллын 3.1, 4.0 хувилбар, секторын ангилал, төрийн бус байгууллагын чиг үүргийн ангиллын дагуу кодолж, өнөөгийн мэдээллийн сангийн бүтцэд хөрвүүлсэн.

2.3.3 ТАРХААЖ БУЙ МЭДЭЭЛЭЛД ХИЙСЭН ХЯНАЛТ МОНИТОРИНГ

Олон улсын жишигт нийцүүлэн албан ёсны статистикийн мэдээллийг буруу, ташаа тайлбарлах, урвуулан ашиглах тохиолдолд залруулах, тайлбар хийх үйл ажиллагааг зохицуулах, шинжлэх ухааны үндэслэлтэй, нэгдсэн тайлбар бүхий хариу арга хэмжээг цаг алдалгүй, шуурхай авах зорилго бүхий “Статистикийн мэдээллийг урвуулан ашиглах, буруу, ташаа тайлбарлах тохиолдолд тайлбар хийж залруулах журам”-ыг шинэчлэн боловсруулж, батлан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Статистикийн салбарын хэмжээнд цуглуулж, нэгтгэн боловсруулж, тархааж байгаа статистикийн мэдээ, тайлан, эцсийн бүтээгдэхүүнд гарч буй алдааг илрүүлэх, баримтжуулах, залруулах, алдааны төрөл, шалтгаанд дүн шинжилгээ хийх, статистикийн чанарын шалгууруудыг бүрэн хэрэгжүүлэх зорилгоор “Статистикийн мэдээллийн алдааг илрүүлж, засвар, баримтжуулалт хийх журам”-ыг шинэчлэн боловсруулж, батлан мөрдөн ажиллаж байна.

ҮСХ-ноос сар бүр монгол, англи хэлээр тархаадаг “Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал” танилцуулга, Статистикийн жилийн эмхэтгэлд мэдээлэл боловсруулах болон мэдээллийн хэвлэлийн эх бэлтгэлийн явцад дунджаар 16 бүлгийн 138 хүснэгт, 15 хуудас явцад байнгын хяналт тавьж ажиллалаа.

Сар бүр статистикийн мэдээлэл боловсруулсан ажилтан, мэдээллийг хянасан холбогдох нэгжийн ахлах статистикч, хэлтэс, газрын дарга, ҮСХ-ны дэд дарга, дарга, Дотоод аудит, мониторингийн хэлтэс гэсэн шат дарааллын хяналтын хуудас, холбогдох мэдээллийг жил бүрээр архив үүсгэн хадгалж байна.

Статистикийн нэгдсэн мэдээллийн сан www.1212.mn-д байршуулсан 16 бүлгийн 330

хүснэгтийн мэдээллийг үзүүлэлт нэг бүрээр анхан шатны мэдээлэл, бусад эх үүсвэр, тооцоотой тулган шалгаж, илэрсэн алдаа, мэдээллийн зөрүүг арилгах ажлыг тухай бүрд нь шуурхай зохион байгуулан ажиллав.

ҮСХ-ны ажлын хэсэг статистикийн мэдээллийн нэгдсэн сангаар тархааж буй бүх мэдээллийг задаргаа бүрээр олон улсын Open Data Watch ашгийн бус байгууллагын статистикийн мэдээллийн нээлттэй байдалд (21 салбарын 80 гаруй үзүүлэлт хамаардаг) хийдэг үнэлгээний аргачлалын дагуу өөрийн үнэлгээг зохион байгуулсан. Энэ ажлын хүрээнд:

- Статистикийн мэдээллийн нэгдсэн санд 736 хүснэгтээр тархааж буй олон жилийн динамик үзүүлэлтүүдийг цаашид 234 хүснэгтээр нэмж, аймаг, нийслэлийн түвшинд тооцох боломжийг тодорхойлж, захиргааны бүртгэл, мэдээллийг ашиглах зарим эх үүсвэрийг шинээр бий болгосон. Тухайлбал: гэмт хэрэг, эрүүл мэнд, боловсролын статистикийн аргачлал, ойлголт, тодорхойлолтыг монгол, англи хувилбараар, мөн хохирогч иргэд, гэмт хэрэг үйлдэгч иргэдийн тоог гэмт хэргийн төрөл, насны ангилал, 2007-2018 оноор бэлтгэн мета мэдээллийн санд тус тус байршуулсан.
- Салбаруудын мэдээлэл хариуцсан албан хаагчтай хамтран мэдээллийг зохих ангиллын дагуу хугацаанд нь байршуулсан эсэхийг шалгаж, баяжуулах талаар чиглэл өгч ажилласан. Тухайлбал, Статистикийн мэдээллийн нэгдсэн санд боловсролын үр дүнгийн үзүүлэлт болох элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж онооны хүснэгтийг шинээр нэмж оруулсан.
- Мета мэдээллийн сангийн баяжилт болон үзүүлэлтүүдийн мета мэдээллийн боловсруулалтад хяналт үнэлгээ хийж, мета мэдээллийн дутуу үзүүлэлт, үзүүлэлтийн тайлбарыг монгол, англи хэлээр нөхөж байршуулсан.

2.4 АРГАЧЛАЛ, АНГИЛЛЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ

Олон улсад нийтлэг мөрдөгдөж буй нийгэм, эдийн засаг, байгаль орчны статистикийн арга зүйг судалж, үндэсний онцлогт тохируулан боловсруулах ажлын хүрээнд

2019 онд нийт 4 ангилал, 5 аргачлал, 25 багц асуулга, маягт, нөхөх заавар, 1 тооцоо, 12 түүврийн загварыг шинээр болон шинэчлэн боловсруулан баталж, мөрдүүлсэн. Эдгээрээс шинээр 2 ангилал, 3 аргачлал, 13 багц асуулга, маягт, нөхөх заавар, 4 түүврийн загварыг боловсруулсан байна. (Хавсралт 3)

Олон улсын стандартад нийцүүлэн статистикийн аргачлал, ангилал, түүврийн арга зүйг сайжруулан боловсруулснаар албан ёсны статистикийн тооллого, судалгаа, мэдээний (Хавсралт 4) хүрээ тэлж, хэрэглэгчдэд тархаах үзүүлэлтийн тоо өсөж, мэдээллийн шуурхай, хүртээмжтэй, үнэн зөв бодит байдал сайжирсан. Ялангуяа Тогтвортой хөгжлийн зорилгын тооцох боломжгүй зарим үзүүлэлтүүдийг шинээр тооцож, хэрэгжилтийг үнэлэх боломж улам бүр нэмэгдэж байна.

ҮСХ-ноос 2019 онд “Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал” (ЭЗҮАСА)-ыг шинэчлэн боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яамны “Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сан”-д бүртгүүлж, аймаг, нийслэл, дүүргийн статистикийн албад болон УБЕГ-ын ажилтнуудад танилцуулж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх ажлыг зохион байгуулсан.

Олон улсын ангиллын дагуу “Бүтээгдэхүүний нэгдсэн ангилал”-ыг шинэчлэн, бүтээгдэхүүний жагсаалтыг аж үйлдвэр, хөдөө аж ахуйн салбар, хэрэглээний үнэ, үйлдвэрлэгчийн үнийн бараа, үйлчилгээтэй уялдуулж боловсруулав. Ангилалд 5 бүлэг, 31 анги, 127 дэд ангийн үзүүлэлт нэмэгдэж, 3853 нэр төрлийн бүтээгдэхүүний жагсаалтыг шинэчилсэн.

Статистикийн мэдээлэл боловсруулалтыг сайжруулах зорилгоор “Орхигдсон утгыг орлуулан тооцох арга зүйн гарын авлага”-ыг олон улсад түгээмэл ашиглагддаг нийтлэг аргуудыг судлан боловсруулсан. Энэхүү гарын авлагад түүвэр судалгаа, аж нэгжийн мэдээлэл, захиргааны мэдээлэл зэрэг бүх төрлийн мэдээлэлд орхигдсон утгыг хэрхэн тооцож ашиглаж болох нийтлэг аргуудыг тодорхой жишээгээр дэлгэрүүлж тайлбарласан.

Статистикийн мэдээлэгчийн ачааллыг багасгах, хөрөнгө, нөөцийг хэмнэх зэрэг зорилгоор мэдээлэл цуглуулах үйл ажиллагаанд түүвэр судалгааны мэдээллийг түлхүү ашиглах, цаашид албан ёсны статистикийн үйл ажиллагаанд захиргааны тоо мэдээллийг ашиглах боломжийг

нэмэгдүүлэх чиглэлээр онцгой анхаарч ажиллалаа.

Түүвэр судалгааны загварыг оновчтой боловсруулж, шинжлэх ухааны үндэслэлийг хангаж, нэвтрүүлэх ажлын хүрээнд Малын ашиг шимийн гарцын судалгаа, Цаг ашиглалтын судалгаа, Ажиллах хүчний судалгаа, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа зэрэг 11 түүвэр судалгааны түүврийн дизайныг шинээр болон шинэчлэн боловсруулсан. (Хавсралт 3)

2.5 ҮНДЭСНИЙ ТООЦОО, ШИНЖИЛГЭЭ СУДАЛГАА

ҮСХ-ноос албан ёсны болон захиргааны статистикийн мэдээ болон тооллого, судалгааны мэдээллийг боловсруулан Монгол Улсын эдийн засаг, нийгмийн байдал, бодлогын түвшинд анхаарах асуудлыг хөндсөн шинжилгээ судалгааны 27 ажлыг хийж тархаасан. (Хавсралт 5)

Үндэсний тооцооны ашиглалт, хэрэглээг нэмэгдүүлэх, шинжилгээ судалгааны ажлыг өргөжүүлэх чиглэлээр дараах ажлыг 2019 онд хийж гүйцэтгэлээ. Тухайлбал:

- ДНБ-ийг үйлдвэрлэлийн болон эцсийн ашиглалтын аргаар, оны болон 2010 оны зэрэгцүүлэх үнээр, 2018, 2019 оны жил, улирлын гүйцэтгэлийн тооцооллыг хийсэн.
- ДНБ-ийг орлогын аргаар, бүс нутаг, өмчийн хэлбэр, эдийн засгийн сектороор 2018 оны гүйцэтгэлээр тооцсон.
- Далд эдийн засгийн тооцооллыг талбаруудаар 2018 оны гүйцэтгэлээр тооцож ДНБ-ий тооцоонд тусгасан.
- Үндэсний тооцооны урсгал, хөрөнгийн болон санхүүгийн дансыг 2018 оны гүйцэтгэлээр байгуулж, танилцуулга бэлтгэж тархаасан.
- Хөрөнгийн биет хэмжээний өөрчлөлтийн данс, хөрөнгийн дахин үнэлгээний дансыг 2018 оноор туршилтаар байгуулсан.
- Нөөц ашиглалтын хүснэгт, Салбар хоорондын тэнцлийг 2017 оны гүйцэтгэлээр байгуулж, үр дүнгээр нь Үндэсний тооцооны үзүүлэлтүүдийг шинэчилж тооцсон.
- Хөрөнгө оруулалт, бүс нутгийн хөрөнгийн нийт хуримтлалыг 2018 оны гүйцэтгэлээр тооцон танилцуулга бэлтгэж тархаасан.
- Байгаль орчин-эдийн засгийн дансны системийн хүрээний дараах 2 дэд дансыг байгуулж, танилцуулга бэлтгэн нийтэд тархаасан. Үүнд:
 - ✓ Материалын урсгалын данс: 2005-2018 он
 - ✓ Байгаль орчны татварын данс: 2015-2018 он
- Эрчим хүчний биет урсгалын данс байгуулах мэдээллийн эх үүсвэрийг сайжруулах ажлын хүрээнд хатуу хог хаягдал түүнээс гарах эрчим хүчийг тодорхойлох арга зүйг судалсан эрчим хүчний бүтээгдэхүүнийг теражоульд хөрвүүлэх үндэсний хөрвүүлэлтийн коэффициентийг боловсруулав.
- НҮБ-ын Ази Номхон Далайн орнуудын эдийн засаг, нийгмийн комисс болон Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран “Байгаль орчин-Эдийн засгийн дансны системийн хүрээний ус, хатуу хог хаягдал болон агаар дахь ялгаруулалтын данснуудыг байгуулах арга зүйн сургалт, семинар”-ыг 2019 оны 3 дугаар сарын 11-14-ний өдрүүдэд зохион байгуулсан. Усны данс, хатуу хог хаягдлын данс, агаар дахь ялгаруулалтын данснуудын олон улсын аргачлалыг судалж, холбогдох мэдээллийг цуглуулж, данснуудыг 2018 оны гүйцэтгэлээр туршилтаар байгуулав. Туршилтаар байгуулсан данснуудын үр дүнгийн хэлэлцүүлгийг холбогдох байгууллагуудын төлөөллийг оролцуулан 2019 оны 10 дугаар сарын 25-нд зохион байгуулж, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлсон.
- Үндэсний Статистикийн хороо, Монголбанкны Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэн хамтран “Үндэсний тооцооны систем-2019” ээлжит хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Энэ хэлэлцүүлэг нь Үндэсний тооцооны системийг нэвтрүүлэгч, оролцогч, хэрэглэгчдийг нэг дор цуглуулж, хэрэгжилт, ашиглалт, хэрэглээний талаарх мэдлэг, мэдээллээ солилцох зорилготой. Хэлэлцүүлэгт ҮСХ-ноос “Эдийн засгийн өсөлт түүнд нөлөөлж буй хүчин зүйлүүд”, “Үндэсний тооцооны данс, Өрхийн сектор” сэдвээр танилцуулга хийлээ.

2.6 МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

Үндэсний Статистикийн хорооноос 2019 онд статистикийн тооллого, судалгаа болон албан ёсны статистикийн мэдээлэл цуглуулах, боловсруулах үйл ажиллагаанд мэдээллийн технологийг өргөнөөр ашиглаж, 17 программ шинээр, 22 программд нэмэлт засвар өөрчлөлт өөрчлөлт хийсэн. (Хавсралт 6)

Төрийн байгууллагуудын статистикийн мэдээллийн сангийн уялдааг хангаж, мэдээллийг дамжуулах ажлын хүрээнд:

- Үндэсний дата төв (ҮДТ)-ийн Нэгдсэн нэвтрэлтийн систем буюу ДАН системийг ашиглан тоон гарын үсэг, гар утасны дугаар, үндэсний цахим шуудангаар дамжуулан систем хөгжүүлэх техникийн тохиргоо, дэд кодчиллыг хийсэн. Энэхүү системийг registration.nso.mn буюу ХАӨМС-ийн мэдээллийг иргэн өөрөө шалгах системийг хөгжүүлсэн.
- Татварын ерөнхий газрын мэдээллийн сангаас ТТ-02 ААНОАТ тайлан, ТТ-03 НӨАТ тайлан, ТТ-11 тайлангуудыг жагсаалт хэлбэрээр ҮДТ-өөр дамжуулан ашиглаж байна.
- Татварын ерөнхий газрын мэдээллийн сангаас ТТ-06 ХХОАТ тайлан, Татвар төлөлтийн мэдээлэл, Татвар төлөгч аж ахуйн нэгж байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн бүртгэлийн мэдээлэл, НӨАТ төлөгч аж ахуйн нэгж байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн мэдээллүүдийн сервисийн кодыг хүлээн авч ҮДТ-д хүргүүлсэн.
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан (www.1212.mn)-ийн загварыг шинэчилж шаардлагатай засвар өөрчлөлтүүдийг тухай бүр хийж ажилласан. Нийт хандалтын тоо 2019 оны 12-р сарын 31-ний байдлаар 3.032.346 байна. Статистикийн мэдээллийн нэгдсэн санг мэдээллээр тогтмол баяжуулж ажилласан. Тухайлбал:
- Хэрэглэгчийн бүртгэлийн программ, www.1212.mn хэрэглэгчийн бүртгэлийг нэгтгэсэн.
- Мета мэдээллийн системийн бүлэг тус бүрийн хайлтын хэсгийг болон ангилал, кодын хэсгийн загварыг сайжруулан шаардлагатай ангиллуудыг нэмж оруулсан.

- Мета мэдээллийн сангийн “Ангилал код”-ын хэсгийг сайжруулж, статистикийн салбарт бүртгэгдсэн 17 төрлийн код, 12 төрлийн ангиллын жагсаалтыг гаргаж ҮСХ, яам, агентлагаас баталсан 19 төрлийн эрх зүйн баримт бичгийг холбогдох эх үүсвэрээс цуглуулж мета мэдээллийн санд оруулсан. Үүнд:
- Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал шинэчлэн батлагдсантай холбогдуулан Хөдөлмөрийн статистик /ажиллах хүчний судалгаа/-ийн мета мэдээллийг монгол, англи хэлээр шинэчлэн оруулсан.
- Цаг ашиглалтын судалгааны 2011, 2015, 2019 оны мета мэдээллийг монгол, англи хэлээр оруулсан.
- Гадаад улс орнуудаас хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч, мэргэжилтний улирлын мэдээ, төрийн албан хаагчийн жилийн мэдээний мета мэдээллийг оруулсан.

Техник, тоног төхөөрөмж, сүлжээний хэвийн ажиллагааг хангах ажлын хүрээнд 2019 онд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Төвийн болон салбар орон нутгийн сүлжээ, утасгүй сүлжээний тоног төхөөрөмжийн нууцлал, аюулгүй байдал, тохиргоо сайжруулалтыг тогтмол хийж ажилласан.
- Нэгдсэн сүлжээний мониторинг хийх (Solarwinds) программын хэвийн ажиллагаанд тогтмол хяналт тавьж, шаардлагатай тохиргоо, үйлчилгээг хийсэн.
- Салбарын хэмжээнд албан хаагчдын ашиглаж буй суурин болон зөөврийн компьютер, принтер, дундын хавтас зэргийг нэгдсэн хяналтад оруулах, албан хаагчдын нэвтрэх нэрийг бүртгэн нэгдсэн бодлого хэрэгжүүлж, үйлдлийн системийн болон вирусээс хамгаалах программ хангамжийн шинэчлэлийг тогтмол хийж ажилласан.
- Төвийн болон салбар орон нутгийн серверүүдийн хаягийг Мобинет ХХК-тай хамтран шинэчлэн илүү найдвартай ажиллагаанд шилжүүлсэн.
- Дотоод мессенжерийн серверт хэрэглэгч нэмэх, хасах, групп шинэчлэх, домэйн сервертэй хэвийн холбогдож ажиллах

зэргээр хэвийн ажиллагааг хангаж ажилласан.

- Файл серверийн хэвийн ажиллагааг хангаж, газар, хэлтсийн албан хаагчдын файлын хавтастай холбоотой үйлчилгээг хийж, нөөцлөлтийг тогтмол хийсэн.
- Вирусээс хамгаалах программын 2019 оны лицензийг серверүүд болон 21 аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтэс, ҮСХ-ны албан хаагчдын компьютерт сунгах үйлчилгээг хийв.
- Техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж, компьютер, принтер, хувилах машин, үйлдлийн систем, хэрэглээний программ, сүлжээ, телефон утасны засвар үйлчилгээ хийж, заавар зөвлөгөө өгч ажиллалаа.
- Аймаг, нийслэл, дүүргийн Статистикийн газар, хэлтэс болон олон улсын сургалт семинарын онлайн хурал хийх "GoToMeeting" программ хангамжийн тохиргоо, үйлчилгээг хариуцан ажилласан.

ҮСХ-ны даргын 2019 оны А/106 дугаар тушаалаар "Мэдээллийн аюулгүй байдлын журам"-ыг нийт 16 бүлэг, 86 зүйлээр шинэчлэн баталж, албан ёсны статистикийн үйл ажиллагаанд мөрдөж байна.

2.7 МЭДЭЭЛЭЛ ТАРХААЛТ

ҮСХ нь Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загвар (GSBPM)-ын дагуу албан ёсны статистикийн мэдээллийг тархаах үйл ажиллагааг олон нийтийн хэрэгцээнд нийцсэн хэлбэрээр зохион байгуулж байна.

ҮСХ нь мэдээллийн нууцлалын болон мэргэжлийн хараат бус, бие даасан байдлын зарчмыг баримтлан жил бүр мэдээлэл тархаалтын нэгдсэн хуваарийг боловсруулан баталж, түүний дагуу албан ёсны статистикийн мэдээллийг цаг хугацаанд нь шуурхай тархаан ажиллаж байна.

Мэдээлэл тархаалтын систем буюу статистикийн мэдээллийн нэгдсэн сан, статистикийн аргачлал арга зүйн мэдээллийн сан, тооллого, судалгааны каталог, тооллогын мэдээллийн сан, хүн ам зүйн үндэсний атлас зэрэг системүүдийг ашиглан тархаалтын бүтээгдэхүүний бэлтгэх, хэрэглэгчдэд сурталчлан таниулах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллалаа.

ҮСХ-ноос статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn, байгууллагын цахим хуудас www.nso.mn, 1900-1212 лавлах утас, цахим шуудан (information@nso.mn) болон бусад хэлбэрээр хэрэглэгчдэд мэдээллээр үйлчилж байна. (Хавсралт 7)

Монгол Улс Олон улсын валютын сангийн мэдээлэл тархаалтын тусгай стандарт /SDDS/-д 2019 оны 4 дүгээр сарын 2-нд бүрэн шилжиж уг стандартад шилжсэн дэлхийн 76 орны нэг болсон. Олон улсын валютын сангийн сайжруулсан мэдээлэл тархаах ерөнхий стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Монголбанк, Сангийн яамтай хамтран Үндэсний нэгдсэн мэдээллийн цахим санг байгуулж нийгэм, эдийн засгийн 22 салбарын (бодит сектор, төсвийн сектор, санхүүгийн сектор) мэдээний баяжуулалтыг сар бүр шинэчлэн, салбаруудын мэдээллийг олон нийтэд тархааж байна. Сангийн яамнаас улсын нэгдсэн төсөв /GGO/, улсын төсөв /CGO/, Монголбанкнаас албан нөөц хөрөнгө, валютын нөөц, гадаад өрийн шаардлагатай тоо мэдээллийг гаргуулж, статистикийн мэдээлэл, мета мэдээллийг солилцох стандарт /SDMX/-д хөрвүүлж, Олон улсын валютын сан /OУВС/-д хүргүүлэн ажиллаж байна.

Олон улсын байгууллагуудад нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийн мэдээллийг хэвлэмэл байдлаар тархааж, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Олон улсын валютын сан зэрэг байгууллагуудад нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийг тусгайлан бэлтгэж сар бүр мэйл хаягаар илгээж байна.

Олон улсын байгууллагуудад Монгол Улсын эдийн засаг, нийгмийн албан ёсны статистикийн үзүүлэлт, тооцоог боловсруулан хүргүүлэн ажиллав. Тухайлбал:

- Гадаад худалдаа, аж үйлдвэр, хэрэглээний үнэ, үйлдвэрлэгчийн үнийн индексийн мэдээг SDMX форматад хөрвүүлэн Олон улсын валютын санд хүргүүлсэн.
- Аж үйлдвэр, хэрэглээний үнэ, хөдөө аж ахуйн салбарын мэдээллийг НҮБ-ын статистикийн хэлтэс, НҮБ-ын Хөгжлийн байгууллага, Олон улсын эрчмийн агентлаг, Дэлхийн банкинд хүргүүлсэн.
- Өрхийн хэрэглээний бараа, үйлчилгээг үнэ судлагдаж байгаа байдлаар нь тодорхойлж Азийн хөгжлийн банкинд хүргүүлсэн.

- НҮБ-ын Статистикийн хэлтсээс ирүүлсэн “Статистикийн бизнес регистрийн гарын авлага”-ыг судлан, өөрийн орны туршлагыг тус гарын авлагад оруулахаар санал боловсруулж хүргүүлсэн.

Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn цахим хуудасны дизайн, бүтцийг ашиглахад илүү ойлгомжтой байдлаар шинэчлэв. Энэхүү мэдээллийн санд монгол, англи хэлээр 36 салбарын 774 статистик үзүүлэлтийг улс, бүс, аймаг, сум, багийн түвшинд 1921-2019 оноор бүрдүүлж, жил, улирал, сарын давтамжтай шинэчлэн баяжуулж байна.

Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn цахим хуудасны файлын сан болон газарзүйн мэдээллийн сан гэсэн цэсийг тухай бүрд нь баяжуулж, боловсронгуй болгосноор 2019 онд сайтын хандалтын тоо 1076.3 мянга болж, өнгөрсөн оныхоос 43.1 хувиар өссөн.

ҮСХ-ны фейсбүүк хуудсанд 2019 онд цаг үеийн үйл явдлын мэдээ болон видео шторк, инфографик зэрэг 490 мэдээллийг байршуулснаар мэдээлэл авагчдын тоо өнгөрсөн оноос 20.0 хувиар өсөж, хэрэглэгчийн хандалт 40.1 мянга болов.

Твиттер хуудсанд 440 мэдээлэл байршуулсныг үзсэн дагагчийн тоо 24.0 мянга болж, 2018 оны жилийн эцсээс 2.8 хувиар нэмэгдсэн байна.

Олон нийтэд цахим уншлагын үйлчилгээ үзүүлэх зорилгоор <http://esan.mn> системтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, ҮСХ-ноос 2019 онд эмхэтгэн гарсан 40 танилцуулга, судалгааг нийт хэрэглэгчид үнэгүй уншиж танилцах эрхтэйгээр, 2018 оны статистикийн эмхэтгэлийг нийлүүлж ажиллав.

Статистикийн газар зүйн мэдээллийн санг баяжуулж бусад сантай байршлаар холбох, тооллого судалгааны үр дүнг газар зүйн байршлаар тархааж байгаа нь мэдээллийн бодит байдлыг сайжруулах хөшүүрэг болохоос гадна статистикийн мэдээллийг хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлж байна. Энэ чиглэлээр 2019 онд дараах ажлыг шинээр хийсэн.

- Аймагийн төвүүдийн хүнсний гол нэрийн барааны үнэ, шатахууны үнийн мэдээллийг веб газарзүйн мэдээллийн систем ашиглан хэрэглэгчдэд 7 хоног бүр сонирхолтой байдлаар тархааж байгаа

бөгөөд мэдээллийг иргэд ашиглах боломжийг бүрдүүлсэн.

- Байшин, орон сууцны тооллогын үр дүнг газарзүйн мэдээллийн санд оруулан, аймаг, дүүрэг бүрээр цахим аппликейшн боловсруулж тооллогод ашигласан.
- Нүүдэлчин өрхийн туршилтын судалгааны түүврийн загварыг боловсруулахад газар зүйн мэдээллийн системийг анх удаа ашиглаж, Булган аймгийн 4 сумын газрын зургийг Collector программд бэлтгэж оруулсан.
- Байшин, орон сууцны 2019 оны тооллого болон Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын бэлтгэл ажлын хүрээнд Хүн ам, өрхийн мэдээллийн сан дахь кадастрын суурь зургийг шинээр мөрдөж буй хаягийн зургаар шинэчилсэн. Мөн өрхийн байршлын алдааг тогтмол шалгаж алдааг анхан шатанд мэдээлж улмаар аймаг сум дамнасан байршлын алдааг автоматаар шалган илрүүлж байршлын алдаа хэсэгт нэмсэн.

“Монгол Улсын Статистикийн жилийн эмхэтгэл-2018” номыг 2000-2006, 2016-2018 онуудыг харуулсан нийт 10 жилийн үзүүлэлтээр бэлтгэж, бүлэг бүрийн үзүүлэлтийг тооцох аргачлал, нэр томъёоны тайлбарыг оруулж, тухайн салбарын онцлох үзүүлэлтийг инфографикаар харуулсан байдлаар 1500 ширхэг хэвлүүлж УИХ, холбогдох яам, агентлаг, орон нутгийн статистикийн газар нэгж, олон улсын байгууллагуудад хүргүүлсэн.

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн сарын танилцуулгыг монгол, англи хэлээр 3650 ширхэг, нугалбарыг 4300 ширхэг, улирал бүрийн дундаж цалингийн инфографикийг 1200 ширхэг, “Статистикийн өврийн дэвтэр-2018” эмхэтгэлийг 800 ширхэг тус тус хэвлэн олон нийтэд хүргэсэн.

ҮСХ-ноос 2019 онд зарим судалгаа, шинжилгээний ажил болон тайланг хэрэглэгчдэд тухай бүр сурталчлан таниулж, судалгаа хийхэд ашигласан мэдээллээр статистикийн нэгдсэн санг баяжуулан ажиллалаа.

ҮСХ-ноос статистикийн мэдээллийг илүү өргөн хүрээнд тархаах зорилгоор сар бүр хэвлэл мэдээллийн байгууллагуудыг оролцуулан хэвлэлийн бага хурлыг тогтмол зохион байгуулж байгаа нь олон

улсын статистикийн байгууллагуудад сайн туршлага болж байна.

ҮСХ-ноос зохион байгуулж буй хэвлэлийн бага хуралд 30-35 хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл (10-14 телевиз, 6-8 сонин, мэдээллийн 8-10 вэбсайт) тогтмол оролцож статистикийн мэдээллийг хэрэглэгчдэд хүргэж байна. Мөн статистикийн хэрэглэгчдийн санал, хүсэлтийг авах, тэдний саналыг үндэслэн статистикийн байгууллагаас гаргаж буй бүтээгдэхүүний чанарыг сайжруулахад анхааран ажиллалаа.

Статистикийн зарим мэдээлэл, байгууллагын үйл ажиллагааны талаар ҮСХ-ны ажилтнууд хэвлэл, мэдээллийн хэнд тодруулга, ярилцлага өгөх, телевизийн шууд нэвтрүүлэгт (MYOPHT, Eagle, "V", MNC, Эх орон телевиз) оролцох зэргээр мэдээлэл тархаалтын боломжит бүх хэлбэрийг ашиглаж байна. Монголын үндэсний телевизийн "Өглөө хөтөлбөр"-өөр ҮСХ-ны дарга болон ажилтнууд статистикийн мэдээллийг тооцон гаргаж буй аргачлал, арга зүй түүнд оруулсан өөрчлөлтийг тухай бүр хэрэглэгчдэд тайлбарлан таниулах 17 цуврал нэвтрүүлгийг бэлтгэн тархаасан.

Хэрэглэгчдэд шинэ мэдээллийг шуурхай хүргэх ажлын хүрээнд <https://mailchimp.com/> тусламжтайгаар хэрэглэгчийн бүртгэлд бүртгүүлсэн нийт 7000 орчим и-мэйл хаяг руу сарын мэдээний танилцуулгыг сар бүр, судалгааны үр дүнгийн тайланг тухай бүр илгээв.

Статистикийн тоо мэдээлэл авахаар байгууллагын information@nso.mn хаягаар 2019 онд ирүүлсэн 420 хүсэлтийн хариуг өгч ажилласан.

ҮСХ-ны номын санд 2019 онд хандсан статистикийн мэдээлэл хэрэглэгч 1180 хүнд (дунджаар өдөрт 5 хүн) хүссэн мэдээллийг нь боловсруулан өгч ном товхимлоор үйлчилсэн байна.

Статистикийн мэдээллийн лавлах 1900-1212 лавлах утсаар өдөрт дунджаар 10 хүнд үйлчилдэг бөгөөд 2019 онд лавлах утсанд хандсан 1230 хүнд статистик мэдээллийн үйлчилгээг үзүүлэв.

Онлайн чатаар 2019 онд 3750 хэрэглэгч мэдээлэл авсан нь 2018 оноос 33.3 хувиар нэмэгдсэн байна.

Статистикийн мэдээлэл хэрэглэгчдийн бүртгэлийн программыг 2019 онд шинэчилсэн

бөгөөд хэрэглэгчийн бүртгэлийн санд бүртгэлтэй хэрэглэгчдэд Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын талаарх танилцуулга мэдээллийг цахим хэлбэрээр сар бүр хүргэж байна.

ҮСХ нь статистикийн бүх бүтээгдэхүүнд зориулсан нэгдсэн загвар боловсруулан түүнийгээ ашиглахын зэрэгцээ статистик мэдээллийг сайжруулах зорилгоор хэрэглэгчдэд зориулсан семинарыг тогтмол зохион байгуулж ажилласан.

Статистикийн салбарын мэдээллээр (ДНБ, төсөв, гадаад худалдаа, мөнгө, хүн ам, эрүүл мэнд, боловсрол, дундаж цалин, ажиллах хүч, гэмт хэрэг, тээвэр, аж үйлдвэр, өрхийн орлого зарлагын салбарын мэдээлэл) сар бүр, тусгайлсан сэдвээр (Монгол Улсын нийт зээлийн дансны тоо, Монголын цагаан сар, Монгол Улсын 100 ба түүнээс дээш настан, Цусны донорууд статистикийн нүдээр, 2 сарын 14 ба гэрлэлтийн статистик, 3 сарын 8 ба Монгол эмэгтэйчүүд, 3 сарын 18 ба Монгол эрэгтэйчүүд, 6 сарын 1 ба Монгол хүүхдүүд, 7 сарын 11 ба Монгол наадам, 10 сарын 1 буюу Ахмадын баяр, 11 сарын 26-ны Улстунхагласны өдөр гэх мэт) тухай бүр инфографик бэлтгэн тархааж байна. Хэрэглэгчдэд хамгийн их хүрсэн нь 3 сарын 8-ны Монгол эмэгтэйчүүд инфографик нь нийт 317 хэрэглэгч бусдадаа түгээж 64085 хүн сонирхож танилцсан байна.

ҮСХ-ноос статистикийн байгууллагын үйл ажиллагаа, тооллого, судалгааны явц, үр дүн, статистикийн бүтээгдэхүүний видео шторк сурталчилгааг 2019 онд дараах сэдвээр бэлтгэн олон нийтэд тархаасан. Тухайлбал:

- Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын сурталчилгааны видео шторк;
- Мал, тэжээвэр амьтдын 2019 оны жилийн эцсийн тооллогод идэвхтэй хамрагдахыг уриалсан 3 видео шторк;
- Сэтгүүлчдэд зориулсан "Статистикийн мэдээллийн үнэ цэн" сэдэвт сургалтын 3 видео;
- Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын танилцуулгаар сар бүр монгол, англи хэлээр 2 видео тус тус бэлтгэн хэрэглэгчдэд хүргэсэн.

2.8 УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

“Үндэсний статистикийн салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд салбарын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Статистикийн хууль эрх зүйн орчныг төгөлдөржүүлэх, төрийн байгууллагуудын мэдээллийн сангийн уялдааг хангаж, хэрэглээ, ашиглалтыг нэмэгдүүлэх, статистикийн үйл ажиллагаанд технологийн дэвшлийг хөгжүүлэх ажлын хүрээнд 2019 оны 5 зорилго, 23 зорилтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллав.

Үндэсний Статистикийн хорооны дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга болон аймаг, дүүрэг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын дарга нартай 2019 оны гурвалсан гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

Үндэсний Статистикийн хорооны 2018 оны үйл ажиллагааны тайланг дэлгэрэнгүй болон хураангуй байдлаар бэлтгэн системчилсэн үнэлгээний хамт Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд танилцуулж, ажлаа амжилттай дүгнүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Улсын үзлэг явуулах тухай” 150 дугаар тогтоолын дагуу Үндэсний Статистикийн хороонд Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд улсын үзлэг, шалгалт явагдаж 92.5 % буюу “А” үнэлгээтэй дүгнүүлээ.

Үндэсний статистикийн салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг “Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийн зорилго, зорилтын уялдаа холбооны үнэлгээ хийх заавар, хүснэгт”-ийн дагуу үнэлж, хөтөлбөрийн хэрэгжилтийг АДАПТ программд оруулан ҮСХ-ны даргын 2019 оны 01/277 тоот албан бичгээр Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгуулах саналыг өнөөгийн байдал, салбарын 2020 оны хөгжлийн зорилт, 2021-2022 оны хөгжлийн төсөөлөл, үйл ажиллагаанд тулгарч болзошгүй эрсдэл гэсэн үндсэн 3 хэсгээр бэлтгэж, ҮСХ-ны даргын 2019 оны А/168 тоот албан бичгээр Сангийн яаманд

хүргүүлсэн.

ҮСХ-ноос “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого 2050”-ийн төсөлд 4 удаа санал өгч, Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 болон Дэлхийн ТХЗ-ын шалгуур үзүүлэлт, зорилттой уялдсан байдлын болон оновчтой тодорхойлогдсон эсэхээр үнэлгээ хийж хүргүүлэв. Тус бодлогын баримт бичгийн төсөлд оруулсан үзүүлэлтийг зорилго, зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаатай уялдуулан сайжруулж, Монгол Улсын эдийн засаг, нийгмийн өнөөгийн байдал, цаашдын хөгжлийн төлөв хандлагын тоо мэдээлэл, тооцоог бодит байдалд нийцүүлээ.

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдан мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажлын хэсгийг 2019 оны 2 дугаар сард Тамгын газрын даргын тушаалаар байгуулж салбарын нийт 316 албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан, Төрийн албаны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулав.

Үндэсний Статистикийн хорооны 2019 оны төлөвлөгөөний 5 зорилтын хүрээнд “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг тусгаж хэрэгжилтийг зохион байгуулан ажиллав.

Үндэсний Статистикийн хороо болон нийслэл, аймаг, дүүргийн статистикийн газар, хэлтсийн 170 албан хаагчийн 2019 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газрын мэдээллийн санд бүрэн, үнэн зөв оруулж, тайланг тогтоосон хугацаанд Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. Мөн ажлын байрны чиг үүрэг өөрчлөгдсөн, албан тушаал дэвшсэн, шинээр томилогдохоор нэр дэвшсэн 21 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулах ажлыг зохион байгуулсан.

Үндэсний Статистикийн хорооны Даргын зөвлөл 15 удаа хуралдаж 37 асуудал, Арга зүйн байнгын зөвлөл 22 удаа хуралдаж 32 аргачлал, арга зүй, маягт зааврыг тус тус хэлэлцэн баталсан. Удирдлагын шуурхай хурал 16 удаа хуралдаж, цаг үеийн ажилтай холбоотой 10 үүрэг өгч, биелэлтэд хяналт тавьж ажилласан. ҮСХ-ны даргын 196, Тамгын газрын даргын 370 тушаал тус тус гарсан байна.

Статистикийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг 2019 оны 1 дүгээр сарын 21-23-ны өдрүүдэд, Статистикийн салбарын нэгдсэн зөвлөгөөнийг 10 сарын 30-наас 11 сарын 2-ны өдрүүдэд, “Статистикийн салбарын ололт амжилт” сэдэвт Статистикийн байгууллага үүсч байгуулагдсаны 95 жилийн ойн баярын арга хэмжээг 11 сарын 11-ний өдөр тус тус зохион байгуулсан.

Статистикийн салбарын Удирдах ажилтны зөвлөгөөнөөр мэдээллийн өнөөгийн байдал, анхан шатны мэдээ, мэдээний чанар, түвшин, уламжлалт бус мэдээлэл түүний хэрэглээ ашиглалт, статистикийн мэдээлэл цуглуулах, тархаах, мэдээллийн технологи сэдвээр мэдээлэл хийж, цаашид хэрэгжүүлэх зорилтоо тодорхойлов.

Аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын жилийн ажлын үр дүнг үнэлж, үнэлгээг ҮСХ-ны Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, ажлын үр дүнгээр Орхон, Сүхбаатар, Дорноговь аймгийн статистикийн хэлтсүүд эхний 3 байрт шалгарсан.

ҮСХ-ны 2019 онд хөтлөгдөх хэргийн нэрийн жагсаалтыг Баримт бичиг нягтлан шалгах комиссын 2019 оны 3 дугаар 20-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн баталсан. Хөтлөгдөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2018 оны 121 нэр төрөл бүхий байнга хадгалах 166 хадгаламжийн нэгж, түр хадгалах 179 хадгаламжийн нэгж нийт 345 хадгаламжийн нэгжийг хүлээн авсан. Архивт хүлээн авсан баримтуудыг байнга, түр хадгалах, 70 жил хадгалах хадгаламжийн нэгжээр ангилан бүртгэлд бүртгэн, архивд хадгалсан.

Тайлант хугацаанд ҮСХ-нд 1231 албан бичиг ирүүлснээс хариутай 948 албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлж, иргэдээс 148 өргөдлийг хүлээн авч бүрэн шийдвэрлэсэн. Төрийн болон албаны нууцад хамаарах 20 албан бичгийг хүлээн авч, 5 албан бичгийг бусад байгууллага руу хүргүүлсэн. ҮСХ-ноос гадагш 965 албан бичиг явуулж, иргэд, өөрийн албан хаагчдаас 125 өргөдөл хүлээн авч, шийдвэрлэсэн.

ҮСХ нь 2019 онд олон талт болон хоёр талт хамтын ажиллагааны хүрээнд 388 албан захидал хүлээн авч, 150 албан захидал илгээж, НҮБ, түүний төрөлжсөн байгууллагууд, хамтын ажиллагаатай олон улсын байгууллагуудаас ирүүлсэн 34 асуулгыг бөглөн хүргүүллээ.

2.9 ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

ҮСХ нь 2019 онд хоёр талт болон олон талт гадаад харилцаа, хамтын ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэх, төсөл хөтөлбөрийг зохицуулах, донор болон хөгжлийн байгууллагуудын дэмжлэг, туслалцааг статистикийн салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэхэд чиглүүлж ажиллав.

Олон улс болон бүс нутгийн хэмжээнд статистикийн чиглэлээр зохион байгуулагдсан 94 удаагийн сургалт, семинарт 83 (давхардсан тоогоор 146 хүн) албан хаагчийг хандивлагч байгууллагуудын санхүүжилтээр хамруулж, мэдлэг, ур чадварыг нь дээшлүүлсэн.

Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Ухаалаг засаг” төслийн 2019 оны Чадавхыг бэхжүүлэх төлөвлөгөөний хүрээнд НҮБ-ын гадаад 4 арга хэмжээнд нийт 10 албан хаагч, дотоодын 15 арга хэмжээнд давхардсан тоогоор 800 гаруй албан хаагчийг хамрууллаа.

НҮБ-ын Статистикийн комиссын 50 дугаар чуулганы үеэр 8 удаагийн 2 талт уулзалтуудыг хийж, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцож, Бүгд Найрамдах Казахстан Улсын Үндэсний эдийн засгийн яамны Статистикийн хороотой харилцан ойлголцлын санамж бичиг байгууллаа.

НҮБ-ын Ази, Номхон Далайн орнуудын эдийн засаг, нийгмийн комиссын техникийн дэмжлэгтэйгээр “Байгаль орчин, эдийн засгийн дансны системийн хүрээний усны, хатуу хог хаягдлын болон агаар дахь ялгаруулалтын данс”-уудыг байгуулах ажлыг эхлүүлсэн.

ҮСХ нь “21 дугаар зууны Статистикийн хөгжлийн төлөөх түншлэл” Консорциумын (ПАРИС21) хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны шинэчлэл, туршлага, ололт амжилтын талаар кейс судалгааг боловсруулан гишүүн орнуудын тайланд тусгуулсан.

ПАРИС21-тэй хамтран Статистикийг дэмжих тухай улс орны тайланг (CRESS) боловсруулах ажлыг эхлүүлж, Түүнчлэн ПАРИС21-ын олон улсын зөвлөхүүдтэй хамтран статистик мэдээллийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох арга хэрэгсэл АДАПТ программын сургалтыг яамд, агентлагийн албан хаагчдад зохион байгуулж, мэдлэг чадварыг дээшлүүлсэн.

Тогтвортой хөгжлийн зорилгын дээд түвшний бүлгийн 14 дэх удаагийн уулзалтыг Улаанбаатар хотноо зохион байгуулав. Уулзалтад НҮБ-ын статистикийн хэлтсийн дарга, Олон улсын байгууллага болон хандивлагч байгууллагын төлөөлөл бүхий дээд хэмжээний 30 гаруй төлөөлөгчид оролцов.

НҮБ-ын Хүн амын сан, АНУ-ын Тооллогын товчоотой хамтран “Тооллогод хөдөлгөөнт төхөөрөмж ашиглах нь” ахисан түвшний сургалтыг Улаанбаатар хотноо 2019 оны 8 дугаар сард зохион байгуулж, Ази, Номхон Далайн бүсийн 11 улс орны статистикийн байгууллагын төлөөлөл бүхий 30 гаруй төлөөлөгчийг хамруулсан. Энэ арга хэмжээний үеэр Монгол Улс дахь CSPro программ хэрэглэгч байгууллага, судлаачид, оюутан залуус, сурах сонирхолтой хүмүүсийн туршлага солилцох уулзалтыг зохион байгуулж, 70 гаруй хүмүүс хамрагдаж мэдлэгээ дээшлүүлсэн.

НҮБ-ын эмэгтэйчүүдийн байгууллагатай хамтран Монгол Улсын ТХЗ-ын хяналтад жендэрийн статистикийг гаргах, ашиглах нь” сэдэвт сургалт, семинарыг зохион байгуулж, ТХЗ-ын зарим түлхүүр үзүүлэлтүүдээс Монгол Улсад жендэрийн нэн тэргүүний гэж тодорхойлсон шалгуур үзүүлэлтүүдийг гаргах мэдээлэл гаргагчдын чадавхыг бэхжүүлсэн. Энэхүү сургалт, семинарын хүрээнд Монгол Улсын Жендэрийн статистикийн мэдээллийн чадавхыг бэхжүүлэх төслийн гэрээг байгуулсан.

Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрууд, олон улсын байгууллагын төлөөлөгчдийн албан ёсны статистикийн талаарх мэдлэг, хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор “Статистик-хэрэглээ” сэдэвт 2 дахь удаагийн сургалтыг зохион байгуулж 20 гаруй төлөөлөгчийг хамруулав.

Япон улсын Статистикийн товчоо болон СИНФОНИКА байгууллагатай хамтран Япон Улсын Мэдээлэл харилцаа холбооны технологийг статистикийн үйл ажиллагаанд ашиглах, Газарзүйн мэдээллийн систем, БНСУ-ын Статистикийн газартай хамтран “Статистик ба их өгөгдлийн мэдээллийн технологи”, Бангладеш Улсын Статистикийн товчоотой хамтран Монгол Улсын Хүн ам, орон сууцны тооллого болон Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгаа, БНХАУ-ын Анхуй мужийн Статистикийн Товчоотой

хамтран худалдааны салбарын бүртгэл, тоон мэдээллийн сан, гадаад хөрөнгө оруулалтын бүртгэл зэрэг чиглэлээр туршлага судлах сургалт, уулзалтуудыг тус тус зохион байгуулсан.

Олон Улсын албан ёсны статистикийн боловсролын төвөөс зохион байгуулсан зурагт хуудасны уралдааныг Монгол Улсад анх удаа Үндэсний хэмжээнд зохион байгуулж, 3 бүтээлийг олон улсын уралдаанд илгээж, сурталчлан ажилласан.

Монгол Улсын Үндэсний статистикийн хороо нь Ази, Номхон Далайн бүс нутгийн статистикийн үйл ажиллагаа, олон улсын статистикийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож туршлага хуваалцан байр сууриа илэрхийлэхийн сацуу тодорхой чиглэлээр дээд хэмжээний 5 бүлэг, техникийн зөвлөх 11 багт гишүүнээр ажиллаж байна. Тухайлбал:

- НҮБ-ын АНДОСИ-ийн 2019-2022 оны Удирдах зөвлөлийн гишүүн;
- НҮБ-ын Статистикийн комиссын “Тогтвортой хөгжлийн зорилго-2030” хөтөлбөрийг хэрэгжүүлэх Дээд түвшний ажлын хэсгийн дарга;
- Ази, Америк, Номхон Далайн үндэсний тооллого, статистикийн дарга нарын холбоо /ANCSDAAP/-ны 2018-2020 оны Ерөнхийлөгч;
- 21-р зууны статистикийн хөгжлийн төлөөх түншлэл ПАРИС 21 (PARIS 21) консорциумын Удирдах зөвлөлийн Тэргүүн;
- НҮБ-ын АНДЭЗНК-ын Эдийн засаг, нийгмийн комиссын Эдийн засгийн статистикийн бүсийн хөтөлбөрийн Удирдах зөвлөлийн гишүүн;
- НҮБ-ын АНДЭЗНК-ын Хүн ам, нийгмийн статистикийн Удирдах зөвлөлийн гишүүн;
- НҮБ-ын АНДЭЗНК-ын иргэний бүртгэл, ердийн хөдөлгөөний статистикийн удирдах зөвлөлийн гишүүн;
- Хөгжлийн бэрхшээлийн статистикийн Вашингтон бүлгийн гишүүн.

2.10 ХҮНИЙ НӨӨЦ, СТАТИСТИКИЙН СУРГАЛТ

ҮСХ-ны хүний нөөцийн хөгжлийн бодлого нь боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулахад чиглэгдсэн байдаг.

Статистикийн төв, орон нутгийн байгууллагад нийт 320 албан хаагч ажиллаж байгаагаас Үндэсний Статистикийн хороонд 122, аймгийн статистикийн хэлтэст 129, нийслэл, дүүргийн Статистикийн газар, хэлтэст 69 албан хаагч ажиллаж байна.

ҮСХ нь 2019 оны сургалтын хөтөлбөрийг статистикийн салбарын төв болон орон нутгийн статистикийн байгууллага болон төрийн захиргааны бусад байгууллагууд, статистикийн мэдээлэгч, хэрэглэгчид төдийгүй ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, их дээд сургуулийн оюутнуудад зориулсан сэдэв агуулгаар боловсруулан ажиллалаа. (Хавсралт 8) Тухайлбал:

- Монгол Улсын Статистикийн салбарыг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийн салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зорилтын хүрээнд 2012 оноос статистикийн төв, орон нутгийн байгууллагын албан хаагчдад зориулсан 4 шатлалт сургалтыг зохион байгуулж ирсэн. Сургалтаар статистикийн онолын болон нийгэм, эдийн засгийн салбарын статистик, эконометрик, статистикийн программ хангамж, үндэсний тооцоо, түүврийн дизайн, салбарын хууль, эрх зүйн мэдлэгийг олгож байна. Төв, орон нутгийн статистикийн байгууллагын ажилтнуудад зориулсан сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгуулдаг дөрвөн шатлалт сургалтад 2019 онд нийт 120 ажилтан суралцснаас 24.2 хувь буюу 29 нь аймгийн статистикийн, 11.7 хувь буюу 14 нь нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн ажилтнууд байна.
- Яам, агентлагийн статистикийн асуудал хариуцсан албан хаагчдад зориулсан анхан шатны сургалтыг Төрийн албаны зөвлөл, Санхүүгийн зохицуулах хороо, Авлигатай тэмцэх газар, БОАЖЯ, ХНХЯ, БСШУСЯ, ХХААХҮЯ, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Биеийн тамир, спортын газар, Гадаадын иргэн, харьяатын газар, Үндэсний хөгжлийн газар, Зам, тээврийн хөгжлийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Цаг уур, орчны

шинжилгээний газар, Гаалийн ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн соёл урлагийн газар, Стандарт, хэмжил зүйн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Барилгын хөгжлийн төв, Цагдаагийн ерөнхий газар, ЭМХТ, НЭМГ-ын нийт 30 албан хаагчийг хамруулан 2019 оны 8 дугаар сарын 26-28 өдрүүдэд зохион байгуулсан.

- Статистикийн R программын сургалтаар ҮСХ-ны 5, дүүргүүдийн статистикийн хэлтсийн 5 албан хаагчийг, SPSS программыг ашиглан судалгааны үр дүн боловсруулах нь сургалтаар Говь-Алтай, Завхан, Баянхонгор аймгийн Статистикийн хэлтсийн албан хаагчдыг хамруулан зохион байгуулав.
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Үндэсний хөгжлийн газрын 16 албан хаагчид АДАПТ программ, түүний нэвтрэлт, хэрэглээ ашиглалтын талаар сургалтыг зохион байгуулсан.
- НҮБ-ын АНДОЭЗНК, АХБ, БОАЖЯ-ны 120 албан хаагч оролцсон “Ус, хатуу хог хаягдал, агаарын данс байгуулах”, НҮБ-ын эмэгтэйчүүдийн байгууллага, их, дээд сургуулийн 110 төлөөлөгч оролцсон “Их, дээд сургуулиудын оюутнуудын жендэрийн статистик, ТХЗ, жендэрийн мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх болон мэдээллийн хэрэглээ” сэдэвт сургалтуудыг тус тус зохион байгуулав.
- ҮСХ-ны 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний Статистикийн мэдээллийн чанар, шуурхай байдлыг сайжруулах, төрийн байгууллагуудын статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн уялдааг хангаж, албан ёсны статистикийн хэрэглээ, ашиглалтыг нэмэгдүүлэх зорилт болон “Төрийн албаны тухай” шинэчилсэн хуулийг дагалдан гарсан журмын хэрэгжилтийн хүрээнд Дорноговь, Өмнөговь, Дундговь, Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Сэлэнгэ, Булган, Хөвсгөл, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Архангай, Увс, Баян-Өлгий, Ховд (17) аймгуудын төрийн болон аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөл, сумдын статистикийн асуудал хариуцсан 3040 гаруй мэргэжилтнийг хамруулсан сургалтыг 2019 оны 6, 9 дүгээр саруудад зохион байгуулсан.

- Монгол Улсын “Төрийн албаны тухай” шинэчилсэн хууль 2019 оноос хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Удирдлагын академийн Төрийн албаны сургуулиас 2019 онд зохион байгуулсан төрийн жинхэнэ албан хаагчид зориулсан мэргэшүүлэх багц сургалтад тэргүүн түшмэлийн 5, эрхэлсэн түшмэлийн 12, ахлах түшмэлийн 20 албан хаагчийг тус тус хамруулав.
- Статистикийн улсын байцаагч нарын сургалтыг 113 холбогдох албан хаагчийг оролцуулан зохион байгуулав.
- Нийслэлийн 90 гаруй аж ахуйн нэгжийн захирал, нягтлан бодогч нарт “Статистикийн мэдээллийг веб технологид суурилсан цахим системээр хэрхэн мэдээлэх тухай” сэдвээр сургалт зохион байгуулсан.
- Ази, Номхон Далайн бүсийн 11 улсын статистикийн байгууллагын 30 төлөөлөгч оролцсон “Mobile Census Data Collection with CSPro Android” сэдвээр, Монгол Улсад суугаа Элчин сайдын яамд, Олон улсын байгууллагын 20 төлөөлөгч оролцсон “Статистик-хэрэглээ” сэдэвт 2 дах удаагийн сургалтыг тус тус хийсэн.
- Авлигатай тэмцэх газрын 18 албан хаагч, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 15 судлаачид хууль зүй, гэмт хэргийн статистикийн өнөөгийн байдал, статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн хэрэглээний талаар сургалт зохион байгуулж мэдээлэл өгсөн.
- Гаалийн ерөнхий газрын нийт албан хаагчдад статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн хэрэглээ, судалгаа, шинжилгээний арга зүй сэдвээр, статистикийн асуудал хариуцсан 12 улсын байцаагчид статистикийн мэдээллийн чанар, шуурхай байдлыг сайжруулах сэдвээр, зам, тээврийн салбарын 20 албан хаагчид салбарын статистикийн мэдээллийн хэрэглээ сэдвээр тус тус сургалт зохион байгуулсан.
- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын удирдах ажилтнууд болон бодлого төлөвлөлт, статистик, санхүүгийн асуудал хариуцсан 20 гаруй албан хаагчид статистикийн мэдээллийн чанар, ашиглалт хэрэглээ, цуглуулсан мэдээлэлд анализ шинжилгээ хийх сэдвээр сургалт зохион байгуулав.
- Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2017 оны 77 дугаар тогтоолоор баталсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд “Хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэргийн тухай ойлголт, түүний хор уршиг, хэрхэн урьдчилан сэргийлэх” талаар зөвлөмж бүхий сургалтыг ҮСХ, аймаг, нийслэл дүүргийн статистикийн газар, хэлтсийн албан хаагчдад мэдээлэл өгч сургалт зохион байгуулж, тайланг Нийслэлийн прокурорын газарт хүргүүлсэн.
- Статистикийн мэдээллийн аргачлал, арга зүй, мэдээний маягт, анхаарах асуудал сэдвээр ҮСХ-ны албан хаагчид Монгол Банк, Авлигатай тэмцэх газар, Эрүүл мэндийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Эрүүл мэндийн хөгжлийн газар, Цагдаагийн ерөнхий газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Удирдлагын академи, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны албан хаагчдад мэдээлэл өгч ажиллав.
- Статистикийн мэдээллийн аргачлал, арга зүйг хэрэглээ талаас тайлбарлан мэдээлэх зорилгоор хэвлэл мэдээллийн 20 гаруй байгууллагын төлөөлөл болон МҮОНРТ-ийн албан хаагчдад сургалт зохион байгуулсан.
- Статистикийн боловсрол нь манай үндэсний хэрэгцээ тул жил бүр статистикийн өдрийг тохиолдуулан улс даяар статистикийн байгууллага, мэргэжлийг сурталчилсан танилцуулах хичээлийг ЕБС-ийн төгсөх ангийн сурагчдад заадаг уламжлалтай. Аймаг, дүүргийн статистикийн хэлтсийн ажилтнууд 2019 онд 20 аймаг, нийслэлийн 6 дүүргийн ерөнхий боловсролын 45 сургуулийн 2400 гаруй сурагчдад “Статистикийн боловсрол” сэдэвт хичээл заав.
- Статистикийн мэдээллийн сан www.1212.mn цахим хуудаснаас хэрэгцээтэй мэдээллээ авах тухай сургалтыг 21 аймгийн их, дээд сургуулийн болон мэргэжил сургалт үйлдвэрлэлийн

төвийн нийт 976 оюутанд тухайн аймгийн статистикийн хэлтсийн ажилтнууд зохион байгуулсан.

- Мандах Их сургуультай хамтран Статистикийн улсын III олимпиадыг бизнес удирдлагын чиглэлээр суралцдаг, статистикийн хөтөлбөрийн хичээл судалж буй их, дээд сургуулийн I, II дамжааны оюутнуудын дунд 4 дүгээр сард амжилттай зохион байгуулсан.
- Монголын Математикийн багш нарын академитай хамтран Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд “ЕБС-ийн үдийн хоол 2020-юу идэх вэ? Илчлэг үү? Шим тэжээл үү?” сэдвээр улсын II уралдааныг зохион байгуулж, нийслэлийн 8 дүүрэг, 21 аймгийн 119 багийн 600 гаруй сурагч оролцсон.
- Монгол Улсын “Статистикийн тухай” хуульд заасан тооллого, судалгааг зохион байгуулахтай холбогдуулан УИХ-ын ТГ, аймаг, дүүргийн ЗДТГ, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Эмэгтэйчүүдийн ТББ, ЦЕГ, Нэг цэгийн үйлчилгээний төв, БСГ, ЭМГ, ЕБС-ийн 1150 төлөөлөл оролцсон “Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгаа”-ны, ӨНЭЗС-ны мэдээлэл цуглуулах 115 ахлагч, судлаачийн, Байшин, орон сууцны тооллогын мэдээлэл цуглуулах 108 судлаачийн, Хүн ам, орон сууцны улсын тооллогын мэдээлэл цуглуулах 72 судлаачийн сургалт, семинарыг тус тус амжилттай зохион байгуулав.

2.11 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Үндэсний Статистикийн хорооны 2019 оны үйл ажиллагааны урсгал зардлын төсөв 7585.3 сая төгрөгөөр батлагдсан бөгөөд төрийн сангаас 99.7 хувь буюу 7561.3 сая төгрөгийн санхүүжилтийг авсан байна. Тайлант хугацаанд “Статистикийн эмхэтгэл-2018” болон бусад ном товхимол борлуулж 7.2 сая төгрөгийн өөрийн орлоготой ажиллав.

Төсвийн урсгал зардлыг эдийн засгийн ангиллаар нь авч үзвэл: Ажиллагчдын цалин хөлсөнд 1034.0 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 72.1 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 4651.7 сая төгрөг, бараа үйлчилгээний зардалд 66.2 сая төгрөг,

урсгал засварын зардалд 36.3 сая төгрөг, дотоод албан томилолтын зардалд 18.9 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардалд 14.4 сая төгрөг, тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийн зардалд 122.8 сая, нийт 7147.5 сая төгрөгийг зарцуулсан байна. Зарцуулагдаагүй хөрөнгийн үлдэгдэл 210.9 сая төгрөгийг Сангийн яамны төрийн санд буцааж төвлөрүүлсэн байна.

Монгол Улсын Төсвийн тухай хуульд заасны дагуу ҮСХ, аймаг, нийслэлийн Статистикийн хэлтэс газраас 2020 оны төсвийн төсөл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн саналыг авч, нэгтгэн боловсруулж, 2020 оны төсвийг 15.4 тэрбум төгрөгөөр батлуулсан.

2019 онд урсгал санхүүжилтээр 129.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 164.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хандиваар авсан байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай зөвшилцөн 2144.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассан.

Байшин, орон сууцны тооллогод зайлшгүй шаардлагатай 129.2 сая төгрөгийн таблет компьютер, Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн баяжуулалтын программ, үндсэн хөрөнгийг бүртгэж хянах, тооллогод ашиглах бар код хэвлэх төхөөрөмж, принтер худалдан авч бүртгэлд тусгалаа.

Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хүрээнд 1 тэрбум 155 сая төгрөгийн санхүүжилтийг авч, батлагдсан төсөв төлөвлөгөөний дагуу зарцуулж ажилласан.

Орон нутагт тооллого, судалгаанд ажиллаж буй ажилтнуудын нийгмийн баталгаа, ажиллах нөхцөлийг ханган, аймгийн Статистикийн хэлтсийн дарга, жолооч болон судлаач нарын нийт 120 хүнийг 9.0 сая төгрөгөөр, 24 нэр төрлийн 431 ширхэг тоног төхөөрөмжийг 11.9 сая төгрөг, 3 тээврийн хэрэгслийг 2.3 сая, нийт 23.2 сая төгрөгөөр гэнэтийн ослын даатгалд хамруулсан.

Статистикийн байгууллагын эд хөрөнгийн 2018 оны жилийн эцсийн тооллогын ажлыг зохион байгуулж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас ирүүлсэн маягтын дагуу Үндэсний статистикийн хороонд бүртгэлтэй эд хөрөнгийн судалгааг гарган хүргүүлж, 2018 оны гэрээгээ дүгнүүлсэн.

Өндөр насны тэтгэвэрт гарсан 5 ажилтанд 122.8 сая төгрөг, 18 ажилтанд 12.1 сая төгрөгийн буцалтгүй тусламж, 47 ажилтанд 8.4 сая төгрөгийн шагнал урамшуулал, шинээр мэндэлсэн 13 хүүхдэд 1.3 сая төгрөг, шинээр гэр бүл болсон нэг албан хаагчид 0.5 сая төгрөгийн тусламж дэмжлэгийг тус тус олгосон байна.

Үндэсний статистикийн хорооны даргын тушаалаар Ахмад настнуудад зориулсан үйл ажиллагаа явуулахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор Ахмадын сан байгуулж, байгууллагын урсгал зардлаас хэмнэсэн 18.4 сая төгрөгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу ахмадын санд төвлөрүүллээ.

Хэвлэх цех нь ном товхимол, мэдээний маягт, хагас жилийн мал тооллого, нийгэм эдийн засгийн байдлын сарын танилцуулга, гаалийн мэдээ болон бусад сургалтын материал, гарын авлага, илтгэл, урилга, хөтөлбөр, албан бичгийн хуудас зэрэг нийт 4.7 сая хэвлэлийн даралтат хуудас материал хэвлэсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн баримт, НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Хүн амын сан зэрэг олон улсын байгууллагуудын санхүүжилтээр хэрэгжсэн төслүүдийн 2018 оны санхүүгийн баримтад аудит хийлгэж, “зөрчилгүй” гэсэн дүгнэлттэй гарсан.

Шилэн дансанд мэдээлэл байршуулах график төлөвлөгөө гарган, 27 үзүүлэлтийн дагуу мэдээлэл байршуулахаас давхардсан тоогоор ҮСХ-ны болон төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны сайтад нийт 306 мэдээлэл байршууллаа.

ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН СТАТИСТИКИЙН САЛБАРЫН 2020 ОНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Үндэсний Статистикийн хороо Монгол Улсын статистикийн салбарын 2020 оны зорилгыг “Монгол Улсын Статистикийн салбарыг хөгжүүлэх дунд хугацааны 4 дэх удаагийн үндэсний хөтөлбөрийг боловсруулах, статистикийн ерөнхий үйл ажиллагааны стандартыг нэвтрүүлэх” гэж тодорхойлж байна.

Энэ зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд дараах зорилтуудыг төлөвлөж хэрэгжүүлнэ. Тухайлбал:

- Статистикийн ерөнхий үйл ажиллагааны стандартыг нэвтрүүлж, албан ёсны статистикийн мэдээлэл боловсруулалтыг боловсронгуй болгох;
- Статистикийн үзүүлэлт, аргачлалыг олон улсын ангилал, аргачлал, стандартын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох, статистикийн мэдээллийг баг, хороо, сумын түвшинд задлан нийтийн хүртээл болгох;

- Хүн ам, орон сууцны 2020 оны улсын тооллого болон бусад тооллого, судалгааны үр дүнг боловсруулж, нийтийн хүртээл болгох;
- Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлтүүдийг тооцох аргачлал, арга зүйг боловсронгуй болгож, мета мэдээллийн сангийн баяжилтыг сайжруулах;
- Хоёр талт болон олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх, бататгах, статистикийн салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, олон улсад статистикийн чиглэлээр гарч байгаа өөрчлөлт шинэчлэлт, сайн туршлагаас суралцаж нэвтрүүлэх;
- Албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийн чанарт чиглэсэн гүйцэтгэлийн хяналт мониторинг хийж, статистикийн үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх.

ДӨРӨВ. ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

1. ОРШИЛ

Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 5 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Үндэсний статистикийн хорооны 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, үйл ажиллагааны тайланд тус хорооны Дотоод аудит, мониторингийн хэлтэс үнэлгээ хийв. Системчилсэн үнэлгээг Хууль зүйн яамнаас боловсруулан гаргасан “Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу Үндэсний статистикийн хорооны чиг үүргийн хэрэгжилт, үйл ажиллагааны журам (процессын), хүний нөөцийн хэрэгцээний үнэлгээ, төсөв санхүүгийн үйл ажиллагааг хамруулсан. Үнэлгээг хийхдээ “Албан ёсны статистикийг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн тайлан, Үндэсний статистикийн хорооны 2019 оны үйл ажиллагааны тайлан болон холбогдох бусад баримт материалыг судлан, дүн шинжилгээ хийх системчилсэн үнэлгээний арга зүйг ашигласан болно.

2. ҮНЭЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛ БОЛОН ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ

2.1 Байгууллагын чиг үүргийн хэрэгжилт

Үндэсний статистикийн хороо нь 2019 онд Тамгын газар, Үндэсний тооцоо, шинжилгээ судалгааны газар, Хүн ам, нийгмийн статистикийн газар, Эдийн засгийн статистикийн газар, Мэдээллийн технологийн газар, Дотоод аудит, мониторингийн хэлтэс зэрэг үндсэн газар, нэгжүүд болон орон нутгийн, нийслэл, аймаг, дүүргийн статистикийн газар, хэлтсүүдэд нийт 320 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үндэсний статистикийн хороо нь 2019 онд “Статистикийн мэдээллийн чанарыг сайжруулах, хэрэглээ ашиглалтыг нэмэгдүүлэх, орон нутгийн статистикийн нэгжийн чадавхыг бэхжүүлэх” үндсэн зорилгыг дэвшүүлэн эдгээрийг хэрэгжүүлэх хүрээнд дараах 5 зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд:

1. Статистикийн салбарын хууль эрх зүйн орчныг сайжруулж, статистикийн ерөнхий үйл ажиллагааны стандарт нэвтрүүлэх бэлтгэлийг хангах;
2. Үндэсний тооцооны системийн ашиглалтыг нэмэгдүүлэх, олон жилийн динамик мэдээлэлд үндэслэн шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлэх;

3. Статистикийн мэдээллийн чанар, шуурхай байдлыг сайжруулах, төрийн байгууллагуудын статистикийн мэдээллийн сангийн уялдааг хангаж, албан ёсны статистикийн хэрэглээ, ашиглалтыг нэмэгдүүлэх;
4. Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлтийг бий болгох, тооцох аргачлал арга зүйг нутагшуулах, статистикийн мета мэдээллийн системийн баяжилтыг сайжруулах;
5. Хамтын ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэх, донор болон хөгжлийн байгууллагуудын дэмжлэг, туслалцааг статистикийн салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэхэд чиглүүлэх.

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэхээр 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан 5 зорилго, 23 зорилтын хүрээнд нийт 257 арга хэмжээг 100 хувийн гүйцэтгэлтэй хийж гүйцэтгэсэн бөгөөд зорилтуудын хүрээнд дараах дэвшилтэт, шинэлэг үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна.

- 1) Хүн ам, орон сууцны 2020 оны тооллого явуулах бэлтгэл ажлын хүрээнд

Тооллогын нарийвчилсан төлөвлөгөө, төсвийг батлуулан, бүртгэлд суурилсан аргаар явуулах тооллогын нэгжийн хүрээг тодорхойлж, холбогдох 4 байгууллагын мэдээллийн эх үүсвэр, үзүүлэлтийн бэлэн байдлыг тодорхойлж туршилтын тооллогыг Нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн 3 хороо, Дорнод аймгийн Хэрлэн сумын 3 багт 2019 оны 1 дүгээр сарын 10-16-ны хооронд зохион байгуулав.

- 2) Байшин, орон сууцны тооллогыг анх удаа улсын хэмжээнд бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулж, тооллогын мэдээллийг хаягийн бүртгэлд суурилсан аргаар Collector for ArcGIS программ болон веб аппликэйшн ашиглан зөөврийн төхөөрөмж (таблет)-өөр цуглуулсан.
- 3) Монгол Улсын статистикийн салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зорилтын хүрээнд мэргэжлийн 4 шатлалт сургалтыг зохион байгуулж, статистикийн онол, нийгэм, эдийн засгийн салбарын статистик, эконометрик, статистикийн программ хангамж, үндэсний тооцоо, түүврийн дизайн, салбарын хууль, эрх зүйн мэдлэгийг олгож байна. Мэргэжлийн дөрвөн шатны сургалтад 2019 онд ҮСХ, аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтэс, яам, агентлаг, төрийн бусад байгууллагуудын нийт 120 ажилтан суралцжээ.
- 4) Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээгээр дамжуулан төрийн бусад байгууллагуудтай мэдээлэл солилцон ажиллаж байна. Тооллого, судалгаа, мэдээлэл цуглуулах үйл ажиллагаанд зориулж 17 программ шинээр, 22 программд нэмэлт засвар өөрчлөлт хийсэн.
- 5) Нийгэм, эдийн засаг, байгаль орчны статистикийн олон улсын нийтлэг мөрдөгдөж буй арга зүйг судалж, үндэсний онцлогт тохируулсан арга зүйг боловсруулах ажлын хүрээнд 2019 онд нийт 6 аргачлал, 4 ангилал, 10 салбарын 54 маягтыг шинээр, 98 маягтын шинэчлэн боловсруулж, ҮСХ-ны даргын зөвлөлөөр хурлаар хэлэлцүүлэн батлуулсан байна. Үүнээс албан ёсны статистикийн 36 маягт, захиргааны 112, судалгааны 5 маягт байна.
- 6) Дэлхийн “Тогтвортой хөгжил 2030” хөтөлбөр, Монгол Улсын “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”

бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг дүгнэхэд шаардлагатай эдийн засаг, нийгэм, байгаль орчны үзүүлэлтийг тооцох, мэдээллийн эх үүсвэрийг бий болгох чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж, үндэсний болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Тухайлбал, дэлхийн тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлтийг тооцох боломжийг судлан мэдээллийн бэлэн байдлыг үнэлэхэд 2019 онд 14 үзүүлэлтээр өргөжүүлж, Монгол улсад 244 шалгуур үзүүлэлтээс 132 үзүүлэлтийг тооцох болсон байна. 2019 оны 12 сарын байдлаар ТХЗ-ын нийт 132 үзүүлэлтийг 2015-2018 оны гүйцэтгэлээр гаргаж хэрэгжилтийг хянах системд байршуулан, тухай бүр баяжилтыг хийж хэрэглэгчдэд хүргэж байна.

Тус хороо нь Үндэсний статистикийн хороо нь олон улсын “Үндэсний тооцооны систем-2008” зөвлөмжийг хэрэгжүүлэх, нэвтрэлтийг эрчимжүүлэх чиглэлээр ажиллаж байна. НҮБ-ын Статистикийн комиссын 42-р чуулганаар шинэчлэн гаргасан “Үндэсний тооцооны хэрэгжилтийн үнэлгээ”-ээр үндэсний тооцооны нэвтрэлт 6 түвшинтэй бөгөөд Монгол Улс үндэсний тооцооны санхүүгийн дансыг байгуулснаар 5 дахь түвшинд хүрсэн. Түүнчлэн “Байгаль орчин-эдийн засгийн дансны систем (БОЭЗДС)”-ийн хүрээний дэд дансуудыг үе шаттай байгуулах ажлыг хэрэгжүүлж, НҮБ-ын АНДОЭЗНК-ын зөвлөхүүдтэй хамтран усны данс, хог хаягдлын данс, агаар дахь ялгаруулалтын дансыг байгуулахад шаардлагатай мэдээллийн эх үүсвэрийг тодорхойлсон.

Үндэсний статистикийн хороо нь аймаг, нийслэл, дүүргээс 51 маягт, яам, агентлаг, төрийн болон төрийн бус байгууллагаас 345 маягтаар сар, улирал, жилийн давтамжтайгаар нийгэм, эдийн засаг, байгаль орчны мэдээлэл цуглуулан нэгтгэн боловсруулж, хэрэглэгчдэд тархааж байна. Мөн үндэсний хэмжээнд явуулдаг дор дурдсан судалгаа, тооллогыг тогтсон хугацаанд, бүрэн хамралттайгаар зохион байгуулж байна.

- а. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн судалгаа: 21 аймаг, нийслэлийн 6 дүүрэг, 112 сумын 1700 гаруй цэгээс 60000 гаруй үнэ, тарифыг сар бүрийн 22-28-ны хооронд нийслэлд 7 үнэ цуглуулагч, 17-20-ны хооронд аймагт 21

үнэ цуглуулагч, суманд сумын статистик хариуцсан ажилтнууд цуглуулдаг бөгөөд ҮСХ хэрэглээний үнийн индекс тооцдог. Энэхүү судалгаа нь инфляцийн түвшинг тодорхойлох зорилготой.

- b. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа: Судалгааны мэдээллийг сар бүр цуглуулж, үр дүнг улирлаар гаргадаг. Сар бүр 21 аймаг, 9 дүүргийн нийт 933 өрх, улиралд 2800 өрх, жилдээ 11198 өрхөөс 76 судлаач, 3 хянагч, 22 ахлагч мэдээлэл цуглуулж, анхдагч мэдээллийн чанарт хяналт тавьж ажилладаг. Энэхүү судалгаагаар хүн амын амьжиргаа, ядуурал, хэрэглээний талаарх мэдээллийг гаргадаг.
- c. Ажиллах хүчний судалгаа: Судалгааны мэдээллийг сар бүр цуглуулж, үр дүнг улирлаар гаргадаг. Сар бүр 21 аймаг, 9 дүүргийн сард 1106 өрх, улиралд 3320 өрх, жилдээ 13280 өрхөөс аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын 76 судлаач мэдээлэл цуглуулж, анхдагч мэдээллийн чанарт хяналт тавьж ажилладаг. Энэхүү судалгааны үр дүнгээр хүн амын хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн талаарх мэдээллийг улсын хэмжээнд болон бус нутаг, аймаг, нийслэлийн түвшинд гаргадаг.
- d. Барилгын өртгийн индекс тооцох судалгаа: Барилга, байгууламжийн өртгийн индекс тооцох, ДНБ-ийг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэх тооцоонд ашиглах, барилгын салбарын өртгийн болон үнийн өсөлтийг харьцуулах зорилгоор улирал бүр 21 аймаг, нийслэлийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт баригдаж буй барилга, түүнийг гүйцэтгэж буй ААНБ-аас мэдээлэл цуглуулдаг.
- e. Аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгө, хөрөнгө оруулалтын улирлын судалгаа: ДНБ-ий улирлын тооцоог хийх зорилгоор улирал бүр ААНБ-уудаас хөрөнгө, хөрөнгө оруулалтын мэдээллийг цуглуулдаг.
- f. Цаг ашиглалтын түүвэр судалгаа: Өрх, гэр бүлийн доторх хөдөлмөрийн хуваарилалт, хөлстэй болон хөлсгүй хөдөлмөрт хүн амын зарцуулж байгаа цагийг гаргахаас гадна хүн амын амьдралын хэв маягийг тодорхойлох зорилгоор явуулдаг бөгөөд 2019 онд 21 аймаг, 9 дүүргийн нийт 4000 өрхөөс улирал бүр мэдээлэл цуглуулав. Энэ судалгаа нь өрхийн 12 ба түүнээс дээш насны гишүүдээр хоногийн 24 цагт хийсэн ажил болон тэдгээрт зарцуулсан хугацааг 10 минут тутамд бичиж

тэмдэглүүлдэг онцлогтой.

- g. Салбар хоорондын тэнцэл, нөөц ашиглалтын хүснэгтийг байгуулах: Улс орны эдийн засгийг илүү дэлгэрэнгүй тодорхойлох, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, бараа, үйлчилгээний ашиглалт болон тухайн үйлдвэрлэл дэх орлого бүрдэлтийг нэгдсэн байдлаар харуулах, эдийн засаг дахь эрэлт, нийлүүлэлтийн тэнцэл буюу хэрэглэгчид, үйлдвэрлэгчдийн хоорондын худалдан авалт, борлуулалтыг нэгдсэн байдлаар харуулах зорилгоор 5 жилд нэг удаа энэ судалгааг явуулж, статистикийн бизнес регистрийн санд бүртгэлтэй 150 гаруй мянган аж ахуйн нэгжээс судалгаа авдаг. “Статистикийн тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “б”-д “салбар хоорондын тэнцэл, нөөц ашиглалтын хүснэгтийг 5 жил тутам байгуулна” гэж заасны дагуу суурь НАХ-ийг 5 жил тутам явуулдаг бөгөөд холбогдох судалгааг 5 жил тутам ААНБ-ын зардлын дэлгэрэнгүй судалгаагаар авдаг. Судалгаа шинжилгээний ажлуудын суурь мэдээлэл болж өгдөгөөрөө ач холбогдолтой бөгөөд улс орны эдийн засгийн салбарын бүтэц, тэдгээрийн харилцан нөлөөлөл, тэргүүлэх салбаруудын гүйцэтгэж буй үүрэг, хөрөнгийн хуримтлал, экспорт, импортын бүтэц зэрэг эдийн засгийн хөгжлийн үндсэн асуудалд макро түвшинд үнэлгээ өгөхөд чиглэдэг.

Нөөц ашиглалтын хүснэгт: Бараа, үйлчилгээний үйлдвэрлэл, ашиглалт, түүнчлэн экспорт, импортын хүрээнд эдийн засаг дахь салбаруудын хоорондын харилцан уялдааг харуулдаг. НАХ-ийг байгуулснаараа ДНБ-ий 3 аргын тооцооны гүйцэтгэл хоорондоо тэнцүү болох бөгөөд мэдээллийн уялдаа, эх үүсвэрийг сайжруулах зэрэг статистик талаасаа ач холбогдолтой.

- h. Мал, тэжээвэр амьтдын тооллого: Мал, амьтдын өсөлт, бууралт, сүргийн бүтцэд гарч байгаа өөрчлөлтийг улсын хэмжээгээр болон бүс нутаг, засаг захиргааны нэгжийн хуваарийн дагуу мал, амьтдыг төрөл тус бүрээр нарийвчлан гаргаж, тухайн нэг жилийн доторхи мал сүргийн нөхөн үйлдвэрлэлийн үр дүнгийн холбогдох бүх мэдээллийг үнэн зөв тодорхойлох зорилгоор бүх шатны Засаг дарга нарыг жил бүр мал тооллогын ажлыг зохион байгуулахад мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлага, зөвлөмжөөр хангаж ажилладаг.

- i. Малын хагас жилийн тооллого: Даатгалын нөхөн төлбөр олгоход суурь мэдээлэл болгох зорилгоор энэхүү тооллогыг түүврийн аргаар 3000 гаруй өрхөд явуулдаг.
- j. Хашаа, худаг, тэжээлийн тооллого: Мал ахуйн үйлдвэрлэлд ашиглагдаж буй хашаа, худаг, тэдгээрийн ашиглалт, хангамж, бэлтгэсэн тэжээл, тэжээлийн хангамжийг тодорхойлох зорилгоор 3 жил тутам хийдэг энэхүү тооллогыг 2019 оны мал тооллоготой хамтатган зохион байгууллаа.

Монгол Улсын “Статистикийн тухай” хуульд заасны дагуу албан ёсны болон захиргааны мэдээллийн уялдаагхангах, арга зүйн нэгдмэл байдлыг хангах, үзүүлэлтүүдийг баяжуулах, давхардалгүй байлгах үүднээс Сангийн яам, Зам тээврийн хөгжлийн яам, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Цагдаагийн ерөнхий газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Гаалийн ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Жендэрийн үндэсний хороо, Төрийн албаны зөвлөл, Гааль татварын санхүүгийн мэдээллийн технологийн төв УУГ, Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл, Хуульчдын холбоо зэрэг байгууллагуудын захиргааны мэдээллийн нийт 112 маягт, нөхөх заавар, үзүүлэлтийн хүрээг боловсруулахад хамтран ажиллаж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах зөвшөөрлийг өгсөн байна. Түүнчлэн захиргааны статистикийн мэдээллийн чанарыг улам сайжруулах, анхан шатны нэгжид ажиллаж буй ажилтнуудад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор БСШУСЯ, ЭМЯ-тай хамтран баталсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу 2019 онд 10 аймгийн 96 сум, 547 баг, 766 байгууллагад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг хорооны дарга, БСШУС-ын сайд, Эрүүл мэндийн сайдад хүргүүлж ажилласан байна.

Яам, агентлагийн статистик хариуцсан албан хаагчдад зориулсан анхан шатны, 3 өдрийн сургалтыг зохион байгуулж, Төрийн албаны зөвлөл, Санхүүгийн зохицуулах хороо, Авлигатай тэмцэх газар, БОАЖЯ, ХНХЯ, БСШУСЯ, ХХААХҮЯ, Зам, тээврийн хөгжлийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Цаг уур, орчны шинжилгээний газар, Гаалийн ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн соёл урлагийн газар, Стандарт, хэмжил зүйн газар, Хөдөлмөр,

халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Барилгын хөгжлийн төв, Цагдаагийн ерөнхий газар, ЭМХТ, НЭМГ, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Биеийн тамир, спортын газар, Гадаадын иргэн, харьяатын газар, Үндэсний хөгжлийн газрын нийт 30 гаруй албан хаагчийг хамруулсан байна. Мөн Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Үндэсний хөгжлийн газрын 16 албан хаагчид АДАПТ программ, түүний нэвтрэлт, хэрэглээ ашиглалтын талаар сургалтыг амжилттай зохион байгууллаа.

Үндэсний статистикийн хорооны 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу статистикийн мэдээллийн чанар, шуурхай байдлыг сайжруулах, төрийн байгууллагуудын статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн уялдааг хангаж, албан ёсны статистикийн хэрэглээ, ашиглалтыг нэмэгдүүлэх зорилт болон Төрийн албаны тухай шинэчилсэн хуулийг дагалдан гарсан журмыг хэрэгжүүлэх хүрээнд Дорноговь, Өмнөговь, Дундговь, Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Сэлэнгэ, Булган, Хөвсгөл, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Архангай, Увс, Баян-Өлгий, Ховд зэрэг 17 аймгийн төрийн болон хувийн хэвшил, аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөл, сумдын статистик хариуцсан албан хаагч зэрэг нийт 3000 гаруй ажилтнуудыг хамруулсан сургалтыг зохион байгуулав.

Тайлант онд Үндэсний статистикийн системийн ажилтнуудыг мэргэшүүлэх болон давтан сургах, сургалт хөгжлийн системчилсэн төлөвлөгөөний дагуу статистикийн салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, тэдний ур чадварыг нэмэгдүүлэх, салбарын шинээр болон шинэчлэгдэн батлагдсан хууль, дүрэм, журмын талаар мэдлэг, мэдээллээр хангах хүрээнд статистикийн 3897 ажилтан, судалгааны мэдээлэл цуглуулах 1445 судлаач, статистикийн мэдээлэгч байгууллагуудын 90 ажилтныг хамруулсан сургалт хийснээс гадна хэрэглэгчийн боловсролыг нэмэгдүүлэх, статистикийн мэдээллийн ач холбогдлыг ойлгуулах үүднээс 573 хэрэглэгч, ЕБС-ийн 2400 сурагч, 1166 оюутанд сургалт хийсэн байна.

Үндэсний статистикийн хороо нь “Статистикийн тухай” хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа хэвийн, сайн явуулж, албан ёсны статистикийн бүтээгдэхүүн, үйлчилгээ түүний дотор анхан шатны мэдээллийн чанарыг хангаж, чанартай, бодитой

мэдээллээр бүх түвшний хэрэглэгчдийг ижил тэгш, шуурхай хангахад анхаарч статистикийн үйл ажиллагаанд технологийн дэвшлийг өргөн ашигласнаар мэдээллийн нээлттэй байдал нэмэгдэж, хэрэглэгчид статистикийн мэдээллийг орон зайнаас үл хамааран цаг алдалгүй авах боломжийг бүрдүүлсэн байна.

2.2 Байгууллагын хүний нөөц

Статистикийн төв, орон нутгийн байгууллагад нийт 320 албан хаагч ажиллаж байгаагаас Үндэсний статистикийн хороонд 122, аймгийн статистикийн хэлтэст 129, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтэст 69 албан хаагч ажиллаж байна.

Үндэсний статистикийн хорооны ажилтнуудын 70.0 хувь нь санхүү, эдийн засаг, статистик, нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэй, 4.2 хувь нь эрх зүйч, 10.0 хувь нь инженер, программист, 15.8 хувь нь бусад мэргэжлийнх байгаа бөгөөд боловсролын түвшнээр авч үзвэл 2019 онд доктор 2, магистр 33, бакалавр 83, бүрэн дунд боловсролтой 2 ажилтан байна.

Үндэсний статистикийн хорооны нийт албан хаагчдыг насны бүтцээр авч үзвэл 30.0 хувийг 21-25 насныхан, 45.8 хувийг 31-40 насныхан, 18.3 хувийг 41-50 насныхан, 5.8 хувийг 51-60 насныхан эзэлж байна.

Тус хорооны албан хаагчдын 22.5 хувь нь 0-5 жил, 30.8 хувь нь 6-10 жил, 20.0 хувь нь 11-15 жил, 10.8 хувь нь 16-20 жил, 15.9 хувь нь 21-ээс дээш ажиллаж байна.

Салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зорилтын хүрээнд 2012 оноос статистикийн төв, орон нутгийн байгууллагын албан хаагчдад зориулсан 4 шатлалт сургалтыг зохион байгуулж ирсэн бөгөөд статистикийн онолын болон нийгэм, эдийн засгийн салбарын статистик, эконометрик, статистикийн программ хангамж, үндэсний тооцоо, түүврийн дизайн, салбарын хууль, эрх зүйн мэдлэгийг олгодог. Энэхүү дөрвөн шатлалт сургалтад 2019 онд нийт 120 ажилтан суралцсаны 24.2 хувь буюу 29 нь аймгийн статистикийн, 11.7 хувь буюу 14 нь нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн ажилтнууд байна.

Хорооны олон талт болон хоёр талт хамтын ажиллагааг албан хаагчдыг мэргэшүүлэх, чадавхыг нэмэгдүүлэхэд чиглүүлж, олон улс болон бүс нутгийн хэмжээнд статистикийн чиглэлээр зохион байгуулагдсан 94

удаагийн сургалт, семинарт 146 албан хаагч хандивлагч байгууллагуудын санхүүжилтээр хамрагдаж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлж, сайн туршлагаас суралцсан байна.

Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор 57 албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон 103 албан хаагчийн зэрэг дэвийн нэмэгдлийг шинээр болон нэмэгдүүлэн тогтоож, албан хаагчдын гүйцэтгэлийг хагас бүтэн жилийн үр дүнгээр үнэлэн нийт 23 ажилтныг салбарын шагналаар шагнаж, тус шагнал урамшуулалд 2.4 сая төгрөг зарцуулсан байна.

Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилсан сэргийлэх зорилгоор нийт албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулж ажилласан байна.

Хорооны үйл ажиллагааны хамрах хүрээ, статистикийн мэдээллийн эрэлт хэрэгцээ, ач холбогдол, үүрэг роль болон мэдээлэлд хамрагдах нэгжийн тоо эрс өсч байгаатай холбоотойгоор цаашид байгууллагын бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийг улам нарийвчлах, албан тушаалын тодорхойлолтыг холбогдох хууль, журамд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, мөрдөх, хүний нөөцийн талаар баримтлах бодлого (хөтөлбөр)-ийг шинэчлэх, хүний нөөцийг оновчтой хуваарилах, хуульд заасны дагуу тогтвор суурьшилтай ажиллуулах, төрийн албаны мэргэшсэн баг бүрдүүлэх, ажилтнуудын нийгмийн асуудлыг шат дараатай шийдвэрлэхэд анхаарч ажиллах, УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо болон бусад байгууллагуудын дэмжлэгийг авах, хамтран ажиллах шаардлагатай байна.

2.3 Байгууллагын үйл ажиллагааны журам (процессын)

Үндэсний статистикийн хороо нь үйл ажиллагаанд хамааралтай хуулиуд, тэдгээрийг дагалдан гарсан журам, заавар, дүрэм, зааврын хэрэгжилтийг хангаж ажиллаж байгаа бөгөөд хорооны даргын тушаалаар баталсан 24 журмыг өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөж байна.

Тус хороо нь Статистикийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 3.2-д заасны дагуу “Монгол Улсын Статистикийн салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг Улсын Их Хурлын 2017 оны 38 тоот тогтоолоор батлуулж, хэрэгжилтийг жил бүр тайлагнаж ирсэн байна. Албан ёсны статистикийг

хөгжүүлэх 2017-2020 оны хөтөлбөр нь 6 үндсэн зорилгын хүрээнд 25 зорилт, эдгээр зорилтыг хэрэгжүүлэх 146 төсөл, арга хэмжээг тодорхойлж, нийт 43.5 тэрбум төгрөг зарцуулахаар анх төлөвлөжээ.

Тайлант онд уг стратегийн төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан бөгөөд нийт төлөвлөсөн 146 үйл ажиллагаанаас, 56 ажлыг бүрэн хэрэгжүүлж, 90 ажил хэрэгжиж байгаа бөгөөд эдгээр ажлуудыг хорооны 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бүрэн тусгаж хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Монгол Улсын “Төрийн албаны тухай” хуулийн дагуу төрийн албан хаагч бүр гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, гүйцэтгэлээ тайлагнаж байна. Мөн Авилгын эсрэг хуулийн дагуу албан хаагчид “Хөрөнгө, орлогын мэдүүлэг”-ийг хуулийн хугацаанд гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлж байна.

2.4 Байгууллагын төсөв, санхүүгийн үйл ажиллагаа

Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4-т заасны дагуу Статистикийн байгууллагын 2019 оны төсөв 10.2 тэрбум төгрөгөөр батлагдсан нь өмнөх онтой харьцуулахад 7.7 хувиар нэмэгдсэн байна.

Статистикийн байгууллагын батлагдсан нийт төсвийн 43.6 хувийг цалингийн зардал, 45.0 хувийг тооллого, судалгааны зардал, 3.0 хувийг байр ашиглалтын зардал, 2.4 хувийг холбооны суваг ашигласны хөлс, 6.0 хувийг бусад зардал тус тус эзэлж байна.

Үндэсний статистикийн хороо нь төсвийн шууд захирагчдаас төсвийн холбогдох мэдээ, тайланг тухай бүр авч нэгтгэн тогтоосон хугацаанд Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хугацаанд нь хүргүүлж ажилласан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудит, мониторингийн хэлтсээс Хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн үйл ажиллагаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан заавар, журмын хүрээнд явагдаж байгаа эсэхэд дүгнэлт өгөх, гарсан алдаа зөрчлийг засаж, залруулах зорилго бүхий 3 удаагийн санхүүгийн

дотоод аудитыг хийж гүйцэтгэн төсвийн шууд захирагч бүрд дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулан хүргүүлсэн байна. Мөн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны эхний хагас жилийн шилэн дансны мэдээлэл байршуулалтад нийцлийн дотоод аудит хийж, зөвлөмж боловсруулан төсвийн шууд захирагч нарт хүргүүлж, мэдээллийг хуулийн хугацаанд нь бүрэн байршуулж хэвшжээ.

Үндэсний статистикийн хорооны даргын төсвийн багцад хамаарах 21 аймаг, нийслэлийн Статистикийн хэлтэс, газар нь 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангаа төрийн аудитын байгууллагын орон нутаг дахь салбар байгууллагуудад Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан хугацаанд хүргүүлж, 5 байгууллага итгэмжлэл авч, аудит хийлгэсэн 17 байгууллага “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан байна. Үндэсний статистикийн хороо нь төсвийн шууд захирагчийн хувьд 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хуульд заасан хугацаанд төрийн аудитын төв байгууллагад хүргүүлжээ.

Монгол Улсын “Төсвийн тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д зааснаар төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 4 дүгээр сарын 05-ны дотор Төрийн аудитын төв байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 25-ны дотор Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлдэг.

Үндэсний статистикийн хороо нь төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах 23 төсвийн шууд захирагчдын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд Төрийн аудитын төв байгууллагад хүргүүлэхээр ажиллаж байна.

Аймаг, нийслэлийн Статистикийн хэлтэс, газрын санхүүгийн үйл ажиллагааг улам сайжруулах, хууль, эрх зүйн актуудын талаар мэдээлэл өгөх, тэдний ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Сангийн яамны бодлого зохицуулалтын газар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Санхүүгийн тооцоолох групптэй хамтран 11 сард нягтлан бодогчдыг сургалтад хамруулсан байна.

3. ДҮГНЭЛТ, САНАЛ

Тайлант онд Үндэсний статистикийн хороо нь “Статистикийн тухай хууль” болон бусад холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа хэвийн, сайн явуулж, тавьсан зорилтуудаа бүрэн хангасан байна гэж дүгнэж байна. Тус хороо нь төрийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, ашиглах, мэдээллийг нээлттэй болгох, мэдээлэгчид учрах дарамт ачааллыг багасгах, бүх түвшний хэрэглэгчдэд хүртээмжтэй, ашиглахад хялбар байлгах, мэдээлэл холбооны технологийн дэвшлийг ашиглах чиглэлээр төрийн байгууллагуудтай идэвхтэй, санаачлагатай хамтран ажилладаг бөгөөд орчин үеийн хөгжлийн шаардлагад нийцүүлэн их өгөгдөл (big data) ашиглах боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байна. Жишээлбэл: Гааль татварын санхүүгийн мэдээллийн технологийн төв (УҮГ)-ийн нэмэгдсэн өртгийн албан татвар, урамшууллын системийн мэдээллийг ашиглан албан ёсны статистикийн мэдээ гаргах ажлыг эхлүүлэхээр бэлтгэлийг ханган ажиллаж байна.

Цаашид ололт амжилтаа бататгах, байгууллагын үйл ажиллагаа, албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийн хүртээмж, чанарыг улам нэмэгдүүлэх чиглэлээр анхаарвал зохих асуудлаар үнэлгээний багаас дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Эрх зүйн орчин бэхжүүлэх, “СТАТИСТИКИЙН ТУХАЙ” хуулийн хэрэгжилтийг хангах:

- Статистикийн салбарыг 2021-2025 онд хөгжүүлэх дунд хугацааны стратегийн баримт бичгийг боловсруулан УИХ-аар батлуулах;
- “Статистикийн тухай” хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6 дах заалт, УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны 2018 оны 04 сарын 25 өдрийн тогтоолд заасныг бүрэн хэрэгжүүлэх үүднээс яамд бүтэцдээ салбарын статистикийн үйл ажиллагаа эрхлэн гүйцэтгэх нэгжтэй болох асуудалд УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо болон бусад байгууллагуудын дэмжлэгийг авах;

2. Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах:

- Төв, орон нутагт түүний дотор анхан шатны нэгжид ажиллаж байгаа ажилтнуудыг чадавхжуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж дадлагажуулах, салбар бүрийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх цагийг нэмэгдүүлэх үүднээс ҮСХ-ны орон тоог үе шаттайгаар нэмэгдүүлэхэд “Статистикийн тухай” хуулийн 17.4-т заасан “албан ёсны статистикийн мэдээллийг боловсруулах хүчин чадлыг нэмэгдүүлэх, боловсон хүчний чадавхийг дээшлүүлэхэд олон улсын байгууллага, гадаад орнуудын төсөл хэрэгжүүлэх” албан ёсны статистикийн үйл ажиллагааны талаарх Засгийн газрын бүрэн эрхийн хүрээнд холбогдох байгууллагуудын дэмжлэгийг авах;
- Статистикийн үйл ажиллагаанд төдийгүй төрийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээнд цахим мэдээллийг өргөнөөр ашиглаж буй өнөө үед бүх шатны ажилтнуудын компьютер, тоног төхөөрөмж, мэдээлэл солилцох сүлжээний технологийг сайжруулах асуудлаар УИХ-ын ЭЗБХ, Засгийн газар болон холбогдох бусад байгууллагуудын дэмжлэгийг авах;
- Тогтвортой хөгжлийн зорилт (ТХЗ)-ын шалгуур үзүүлэлтүүд тооцох эх үүсвэр тогтвортой, найдвартай, тогтмол баяжуулах боломжтой байх, мөн төрийн байгууллагуудын нэгдсэн мэдээллийн санг баяжуулах, улам сайжруулах, статистикийн үйл ажиллагаанд технологийн дэвшлийг илүү өргөн хүрээнд ашиглах, төв, орон нутгийн статистикийн байгууллагуудын технологийн чадавхыг сайжруулахад статистикийн байгууллагын төсөв, санхүүгийн асуудал чухал байгааг анхааралдаа авч, холбогдох байгууллагуудын дэмжлэгтэйгээр бодит үр дүнд хүрэх.

Ажлын хэсэг

---оОо---

ХАВСРАЛТ

ХАВСРАЛТ1. ДЭЛХИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДЭЭС МОНГОЛ УЛСЫН ХЭМЖЭЭНД ГАРЧ БАЙГАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Зорилго	НҮБ-аас баталсан үзүүлэлт	Монгол улсад хамаарах үзүүлэлт	Үүнээс: оноор			
			2016	2017	2018	2019
Зорилго 1: Ядуурлыг устгах	14	14	2	7	7	8
Зорилго 2: Өлсгөлөнг зогсоох	13	13	4	6	7	7
Зорилго 3: Эрүүл мэндийг дэмжих	27	25	16	16	16	17
Зорилго 4: Чанартай боловсролыг дэмжих	11	11	3	8	8	9
Зорилго 5: Жендэрийн тэгш байдлыг хангах	14	13	0	8	8	9
Зорилго 6: Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах	11	11	6	5	6	6
Зорилго 7: Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх	6	6	3	4	4	5
Зорилго 8: Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих	17	17	10	13	13	14
Зорилго 9: Инновац болон дэд бүтцийг хөгжүүлэх	12	12	3	6	6	6
Зорилго 10: Тэгш бус байдлыг бууруулах	11	11	1	4	5	5
Зорилго 11: Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих	15	15	1	5	6	7
Зорилго 12: Хариуцлагатай хэрэглээг дэмжих	13	13	1	2	2	3
Зорилго 13: Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах	8	8	2	3	3	4
Зорилго 14: Далай, тэнгисийн нөөцийг хамгаалах	10	2	0	0	0	0
Зорилго 15: Хуурай газрын эко системийг хамгаалах	14	14	4	5	5	5
Зорилго 16: Энх тайван, шударга ёсыг цогцлоох	23	23	2	12	12	17
Зорилго 17. Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх	25	25	2	9	10	10
Нийт	244	233	60	113	118	132

ХАВСРАЛТ 2. ДЭЛХИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ДҮГНЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ 2019 ОНД ӨРГӨЖҮҮЛСЭН БАЙДАЛ.

№	Өргөжүүлсэн үзүүлэлтийн нэр
1	15.4. Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний стратегийн дагуу гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн стратегийг баталж, хэрэгжүүлдэг орон нутгийн засаг захиргааны эзлэх хувь
2	3.b.1 Үндэсний хөтөлбөрт тусгагдсан бүх төрлийн вакцинжуулалтад хамрагдсан зорилтот хүн амын эзлэх хувь
3	4.1.1. (i) Унших болон (ii) тоо бодох наад захын чадварыг эзэмшсэн (a) 2/3-р анги, (b) бага анги төгссөн, (c) дунд анги төгссөн хүүхэд, залуучуудын эзлэх хувь, хүйсээр
4	4.4.1 Мэдээлэл харилцаа холбоо, технологийн ур чадвартай насанд хүрэгчид (15, түүнээс дээш насны) болон залуучуудын (15-24 насны) тухайн насны хүн амд эзлэх хувь, ур чадварын төрлөөр
5	5.6.1. Гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай бөгөөд жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэл (ЖСАХ)-ийг ер нь хэрэглэж байсан, ЖСАХ-ийн хэрэглээ, бэлгийн хавьтал, нөхөн үржихүйн эрүүл мэнддээ анхаарах талаар бие даан шийдвэр гаргадаг 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь
6	7.1.2 Цэвэр түлш, технологийг голчлон хэрэглэдэг хүн амын эзлэх хувь
7	11.b.2 болон 13.1.3. Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний стратегийн дагуу гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн стратегийг баталж, хэрэгжүүлдэг орон нутгийн засаг захиргааны эзлэх хувь
8	16.1.4. Амьдардаг орчиндоо ганцаараа явахад аюулгүй байдлыг мэдэрдэг хүн амын эзлэх хувь
9	16.3.1 Өмнөх 12 сарын хугацаанд хүчирхийллийн хохирогч болсон бөгөөд хамгийн сүүлийн тохиолдлыг эрх бүхий байгууллага болон бусад албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн зөрчил шийдвэрлэх байгууллагад мэдээлсэн хохирогчдын эзлэх хувь
10	16.5.1 Сүүлийн 12 сард төрийн албан хаагчтай хамгийн багадаа нэг удаа харилцсан иргэдээс төрийн албан хаагчдад авлига өгсөн эсвэл төрийн албан хаагчаас авлига нэхүүлсэн хүмүүсийн эзлэх хувь
11	16.6.2 Төрийн албаар үйлчлүүлсэн иргэдээс сүүлийн үйлчилгээндээ сэтгэл хангалуун байгаа иргэдийн эзлэх хувь
12	16.7.2. Шийдвэр гаргалт нь хүртээмжтэй, хариуцлагатай байдагт итгэдэг хүн амын эзлэх хувь
13	16.9.1 Төрөлтийг нь иргэний бүртгэлийн байгууллага бүртгэсэн 5 хүртэлх насны хүүхдүүдийн эзлэх хувь
14	16.b.1 Олон улсын хүний эрхийн хуулиар хориглосон ялгаварлан гадуурхах явдлын аль нэг тохиолдлоор сүүлийн 12 сард гадуурхагдсан, доромжлуулснаа мэдүүлсэн хүн амын эзлэх хувь

ХАВСРАЛТ 3. ҮСХ-НООС 2019 ОНД ШИНЭЭР БОЛОН ШИНЭЧЛЭН БАТАЛЖ МӨРДҮҮЛСЭН АРГАЧЛАЛ, АНГИЛАЛ, ГАРЫН АВЛАГА, МАЯГТ, АСУУЛГА, НӨХӨХ ЗААВАР, ТҮҮВРИЙН ДИЗАЙН

№	Аргачлал, маягт, асуулга, нөхөх зааврын нэр	Тайлбар
А.	Аргачлал	
1	Малын бэлчээрийн даац тооцох нэгдсэн аргачлал	Шинэ
2	Барилгын салбарын статистикийн үзүүлэлтүүдийг тооцох аргачлал	Шинэ
3	Жендэрийн статистикийн үзүүлэлтүүдийн хүрээ, тооцох аргачлал	Шинэчилсэн
4	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоос шалтгаалсан гэмтлийн статистик үзүүлэлт тооцох аргачлал	Шинэ
5	Байгаль орчны статистикийн үндсэн үзүүлэлтүүдийг тооцох аргачлал	Шинэчилсэн
Б.	Ангилал	
1	Эдийн засгийн үйл ажиллагааны бүх төрлийн салбарын ангилал	Шинэчилсэн
2	Хувийн хэрэглээний зориулалттай бараа, үйлчилгээний ангилал	Шинэчилсэн
3	Улс орон, нутаг дэвсгэрийн ангилал, код	Шинэ
4	Дээд боловсролын ангилал, код	Шинэ
В	Асуулга, маягт, нөхөх заавар	
1	Байшин, орон сууцны тооллогын асуулга, гарын авлага	Шинэ
2	Эрүүл мэндээ хамгаалах, өвчлөлөөс урьдчилсан сэргийлэх мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлох судалгааны асуулга, заавар	Шинэ
3	Хүн ам, орон сууцны тооллогын асуулга, заавар, гарын авлага	Шинэ
4	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны асуулга, заавар	Шинэчилсэн
5	Хуульчдын нэгдсэн бүртгэлийн маягт, заавар	Шинэ
6	Хүн амын өрхийн бүртгэлийн дэвтэр, маягт, заавар	Шинэчилсэн
7	Зам тээврийн ослын маягт, заавар	Шинэ
8	Өрийн статистикийн мэдээллийн маягт, заавар	Шинэ
9	Гаалийн ерөнхий газрын захиргааны статистикийн маягт, заавар	Шинэчилсэн
10	Мэргэшсэн жолооч болон авто тээврийн үйлчилгээний маягт, заавар	Шинэ
11	Байгаль орчин захиргааны статистик мэдээллийн маягт, заавар	Шинэчилсэн
12	Авлигын статистикийн бүртгэлийн болон албан ёсны статистикийн маягт, заавар	Шинэ
13	Мэргэжлийн боловсролын салбарын албан ёсны болон захиргааны статистикийн мэдээний маягт, заавар	Шинэчилсэн
14	Ахуйн үйлчилгээний цэгийн хагас, бүтэн жилийн мэдээний маягт, түүнийг нөхөх зааврын төсөл	Шинэ
15	Мал тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллогын маягт, заавар	Шинэчилсэн
16	Төрийн албаны зөвлөлийн төрийн байгууллага, төрийн албан хаагчдын захиргааны мэдээллийн маягт, заавар	Шинэ
17	Газар тариалангийн албан ёсны болон захиргааны статистик мэдээллийн маягт, заавар	Шинэ
18	Мал аж ахуйн захиргааны статистик мэдээний маягт, заавар	Шинэ
19	Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын системийн мэдээллийг ашиглах маягт, заавар	Шинэ

ҮСХ-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2019 ОНЫ ТАЙЛАН

№	Аргачлал, маягт, асуулга, нөхөх зааврын нэр	Тайлбар
20	Хөдөө аж ахуйн үнийн мэдээний маягт, заавар	Шинэчилсэн
21	Ажиллах хүчний болон хөдөлмөрийн дутуу ашиглалтын судалгааны асуулга, заавар	Шинэчилсэн
22	Томоохон ААНБ-ын судалгааны үзэл баримтлал, маягт, заавар	Шинэ
23	Цаг ашиглалтын судалгааны үзэл баримтлал, асуулга, заавар, ангилал	Шинэчилсэн
24	Өрхийн ус хангамж, ариун цэврийн байгууламжийг тодорхойлох судалгааны үзэл баримтлал, асуулга, заавар	Шинэчилсэн
25	Хөдөө аж ахуйн түүвэр судалгааны үзэл баримтлал, маягт, заавар	Шинэчилсэн
Г	Гарын авлага	
1	Орхигдсон утгыг орлуулан тооцох арга зүйн гарын авлага	Шинэ
2	Ротациональ түүврийн дизайн боловсруулах, ашиглах арга зүйн гарын авлага	Шинэ
3	Хуульчдад зориулсан гарын авлага	Шинэ
Д	Тооцоо	
1	2019 онд мөрдөх “Амьжиргааны баталгаажих доод түвшин” тооцоо	Шинэчилсэн
Е	Түүвэр судалгааны дизайн	
1	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа 2020	Шинэчилсэн
2	Ажиллах хүчний судалгаа	Шинэчилсэн
3	Цаг ашиглалтын судалгаа 2019	Шинэчилсэн
4	Аж ахуйн нэгж байгууллагын 2018 оны жилийн эцсийн мэдээ	Шинэчилсэн
5	Хөдөө аж ахуйн 2019 оны хагас жилийн судалгаа	Шинэчилсэн
6	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн судалгаа	Шинэчилсэн
7	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого, зардлын судалгаа	Шинэчилсэн
8	Малын ашиг шимийн гарцын судалгаа	Шинэчилсэн
9	Ус, түүний ашиглалттай холбогдох мэдээллийг цуглуулах судалгаа	Шинэ
10	Иргэдийн сэтгэл хангамжийн судалгаа	Шинэ
11	Шим тэжээлийн дутагдлыг илрүүлэх түүвэр судалгаа	Шинэ

ХАВСРАЛТ 4. ҮСХ-НООС 2019 ОНД ШИНЭЭР БИЙ БОЛГОСОН МЭДЭЭЛЭЛ

№	Үйл ажиллагааны салбар	Хамрах хүрээ, тархаах түвшин	Шинэ мэдээллийн		
			Нэр	Маягт №	давтамж
1	Тээвэр	Улс	Импортоор оруулж ирсэн автомашины тоо, улсаар, төрлөөр	-	жил
2	Тээвэр	Улс	Төмөр замын тээврийн тээвэрлэлтийн мэдээ	T-9	сар
3	Тээвэр	Аймаг, нийслэл	Агаарын тээврийн тээвэрлэлтийн мэдээ	A-ИН-1	сар
4	Төсөв	Улс	Өрийн статистикийн мэдээ	A-ӨС-1 A-ӨС-2	сар
5	ХАА	Аймаг, нийслэл	Газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэгчийн үнийн мэдээ	A-ХАА-10	улирал
6	ХАА	Аймаг, нийслэл	Малын генетик нөөцийн жилийн эцсийн мэдээ	З-МАН-5	жил
7	Гэмт хэрэг	Улс, аймаг, нийслэл, дүүрэг	Зам тээврийн ослын мэдээ	A-ЗТО-1	хагас жил, жил
8	ХАА		Газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэгчийн үнийн сарын мэдээ		сар
9	Хууль зүй, гэмт хэрэг	Улс, аймаг, нийслэл	Хуульчдын нэгдсэн бүртгэлийн мэдээ	A-XX-1 A-XX-2 A-XX-3 A-XX-4 A-XX-5 A-XX-6	жил
10	Хууль зүй, гэмт хэрэг	Улс, аймаг, нийслэл	Авлигатай тэмцэх газрын хэрэг бүртгэлийн 30 маягт, заавар болон захиргааны статистикийн мэдээ	Бүртгэлийн маягт-30, захиргааны маягт-6	сар
11	Эрүүл мэндийн даатгал	Улс, аймаг, нийслэл	Эрүүл мэндийн даатгалын орлого, зарлага	A-ЭМД-1, A-ЭМД-6	жил, сар
12	Эрүүл мэндийн даатгал	Улс	Эрүүл мэндийн даатгалд хамрагдагчид	A-ЭМД-2 A-ЭМД-6,7	жил, сар
13	Эрүүл мэндийн даатгал	Улс, аймаг, нийслэл	Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт үзүүлдэг эмийн борлуулалтын мэдээлэл	A-ЭМД-3, A-ЭМД-9	жил, сар
14	Эрүүл мэнд	Улс	Төрсөн хүүхэд, эхийн мэдээлэл	ЭМЯ-ны төрөлтийн цахим бүртгэл сан	жил, сар
15	Эрүүл мэндийн даатгал	Улс, бүс, аймаг, нийслэл	Эрүүл мэндийн даатгалын байгууллагууд	A-ЭМД-8	жил
16	Оюуны өмч	Улс	Оюуны өмчийн салбарын статистикийн албан ёсны мэдээ	A-ОӨБ	сар
17	Хөдөлмөр эрхлэлт	Улс, бүс, аймаг, нийслэл	Хөдөлмөрийн дутуу ашиглалтын үзүүлэлтүүд	AХС-1	жил, улирал

ХАВСРАЛТ 5. ҮСХ-НООС 2019 ОНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ АЖИЛ

№	Шинжилгээ, судалгааны ажил, танилцуулгын нэр	Гүйцэтгэсэн алба, ажилтны нэр
A	Шинжилгээ, судалгааны ажил	
1	Монгол Улсын эрчим хүчний үр ашиг, хүртээмж, түүнд хийсэн бүтцийн шинжилгээ	Б.Анхзаяа
2	Улаанбаатар хотын агаарын бохирдол ба эрүүл мэнд	О.Норовсамбуу Г.Урангоо
3	Дээд боловсролын үндсэн үзүүлэлтүүдийн төлөв байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээ	Ч.Цогзолмаа Н.Амарбаясгалан
4	Уул уурхайн салбарын эдийн засагт үзүүлсэн нөлөө	А.Алтангэрэл
5	Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд үзүүлсэн хөдөлмөрийн зах зээлийн нөлөө	О.Норовсамбуу
6	Бүс нутгийн нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн компонентийн шинжилгээ	Ч.Тунгалаг, О.Норовсамбуу
7	Монгол Улсын Хүний хөгжил, түүний бүрэлдэхүүн индекс- 2018	Ч.Тунгалаг
8	Согтууруулах ундааны хэрэглээ, үйлдвэрлэлийн өнөөгийн байдал	Б.Уранбилэг
9	Үндэсний тооцооны данснуудад үндэслэсэн дэлгэрэнгүй аналитик дүн шинжилгээ	Б.Гэрэл
10	Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засгийн судалгаа (Эдийн засгийн салбар)	Д.Баасан Ю.Батзоригт
11	Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо судалгаа	Т.Оюунсүрэн
12	Залуучуудын хөгжил судалгаа	Н.Должинсүрэн Г.Урангоо Н.Амарбаясгалан Э.Ариунчимэг
13	Нэг цэгийн үйлчилгээний төв /Түр хамгаалах байр болон олон нийтийн мэдлэг, ойлголт, хандлагыг үнэлэх судалгаа/	Н.Должинсүрэн
14	Хууль зүй, гэмт хэргийн статистикийг олон улсын жишигт нийцүүлэх нь судалгаа	Ц.Дулмаа
15	Өсвөр насны охидын эрт жирэмслэлт, төрөлтийн судалгаа	Г.Урангоо
16	Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны үр дүнгийн тайлан 2018	С.Тодгэрэл Т.Алтанцэцэг Д.Мэндбаяр Э.Золзаяа
17	Монгол Улсын ААНБ-уудын залилангийн эрсдэлийг үнэлэх загварыг тодорхойлох нь	О.Лувсанжамц
18	Салбар хоорондын тэнцлийн үр дүнд үндэслэсэн импортын татварын нөлөөллийн шинжилгээ	Ц.Тэгшжаргал
19	Статистикийн шинжилгээний зарим арга зүйд тулгуурлан компанийн дампуурлыг урьдчилан таамаглах загвар боловсруулах нь	С.Цолмон
20	Макро стресс тестийн шинжилгээг ашиглан банкны сектор дахь зээлийн эрсдэл, эрсдэлийн хөдөлгөөнийг тодорхойлох нь	Ч.Цогзолмаа
21	Улаанбаатар хотын өнгөн хөрсөн дэх хүнд элементүүдийн бохирдлын судалгаанд фактор ба кластер анализын аргуудыг хэрэглэсэн үр дүнгээс	Ц.Бямбасүрэн
22	Малчин өрхийн ядуурлыг хэмжих асуудал	Ч.Отгончулуун
23	Монгол Улсын угсаа овгийн статистик судалгаа	Г. Жаргал
24	Цаг ашиглалтын судалгааны хэрэглээг нэмэгдүүлэх нь	Ч.Цогтбаяр
25	Аюултай хог хаягдал, түүний хор уршиг	Т.Болдмаа
26	Монгол Улсын макро түвшний ерөнхий тэнцвэрт хөдөө аж ахуйн салбарын нөлөөлөл	Г.Түмэндэмбэрэл, Л.Нямбат
27	Их дээд сургуулийн багшид тавигдах шаардлага, түүний хэрэгжилт, нөлөөлөх хүчин зүйлс	О.Наранцэцэг

№	Шинжилгээ, судалгааны ажил, танилцуулгын нэр	Гүйцэтгэсэн алба, ажилтны нэр
В	Салбарын танилцуулга	
1	Үндэсний тооцооны данс: Хэсэг 1. Урсгал болон хөрөнгийн данс, 2018	Б.Баярмаа Ц.Тэгшжаргал
2	Үндэсний тооцооны данс: Хэсэг 2. Санхүүгийн данс, 2018	Ц.Тэгшжаргал
3	Үндэсний тооцооны данс, 2018	Б.Баярмаа
4	Үндэсний тооцооны урсгал болон хөрөнгийн дансыг эдийн засгийн сектороор 2018 оны гүйцэтгэлээр байгуулан 2015-2018 байдлаарх танилцуулга	Үндэсний тооцооны алба
5	Үндэсний тооцооны системийн хэрэгжилт, өнөөгийн байдал	Үндэсний тооцооны алба
6	Байгаль орчин, эдийн засгийн нэгдсэн дансны хүрээнд Материалын урсгалын данс, 2018	Ю.Батзоригт
7	Байгаль орчны татварын данс, 2018	Н.Лхам
8	Санхүүгийн дансны 2018 оны үр дүнгээрх танилцуулга	Үндэсний тооцооны алба
9	Хууль бус үйл ажиллагааны үр дүнг эдийн засагт тооцож оруулах нь: Хар тамхины жишээн дээр	Үндэсний тооцооны алба
10	ДНБ-ий улирлын танилцуулга, 2018	М.Мөнхцэцэг Ю.Батзоригт Ж.Цэрэнханд Б.Мягмархатан
№	Шинжилгээ, судалгааны ажил, танилцуулгын нэр	Гүйцэтгэсэн алба, ажилтны нэр
11	Дотоодын нийт бүтээгдэхүүний 2018 оны урьдчилсан гүйцэтгэлийн танилцуулга	Үндэсний тооцооны алба
12	ДНБ, 2018	Б.Баярмаа
13	Бүс нутгийн ДНБ, Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал, 2018	Б.Баярмаа
14	ДНБ-ий 2016-2018 байдлаар танилцуулга	Үндэсний тооцооны алба
15	Хөдөлмөрийн бүтээмж, 2018	Б.Баярмаа
16	Хөдөлмөрийн бүтээмжийн 2018 оны гүйцэтгэлээр танилцуулга	Үндэсний тооцооны алба
17	Хөрөнгө оруулалт, 2018	М.Мөнхцэцэг
18	Хөрөнгө оруулалтын 2015-2018 оны гүйцэтгэлээр танилцуулга	Үндэсний тооцооны алба
19	Бүс нутгийн хүн амын тоо, өсөлт, хөгжил	Үндэсний тооцооны алба
20	Монгол Улсын Хүний хөгжил, түүний бүрэлдэхүүн индекс, 2018	Ч.Тунгалаг
21	Олон улсын өртгийн зэрэгцүүлэлтийн 2017 оны судалгааны тайлан	Д.Мөнхзул
22	Инфляц, үнийн өөрчлөлт - 2018 онд	Д.Батсүх, Т.Жигжидсүрэн
23	Хэрэглээний үнийн индекс дэх жингийн өөрчлөлтийн нөлөөлөл	Д.Батсүх
24	Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс - 2018 онд	Г.Мөнх-Оргил, Б.Энхтүвшин
25	Үйлчилгээний салбаруудын үйлдвэрлэгчийн үнийн индекс - 2018 онд	Г.Мөнх-Оргил, Б.Энхтүвшин
26	Монгол Улсын мөнгө, зээл, үнэт цаас - 2018 онд	А.Мөнхцэцэг
27	Монгол Улсын төрийн санхүү - 2018 онд	Ч.Мөнхтуул
28	Монгол Улсын гадаад худалдааны салбар - 2018 онд	Н.Адъяадорж
29	Статистикийн бизнес регистр - 2018 онд	Ч.Бүжинлхам
30	Монгол Улсын барилгын салбар - 2018 онд	Д.Баасан
31	Монгол Улсын аж үйлдвэрийн салбар - 2018 онд	Р.Энх-Амгалан, Н.Өлзийханд
32	Монгол Улсын тээврийн салбар - 2018 онд	О.Мандахзориг

ҮСХ-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2019 ОНЫ ТАЙЛАН

№	Шинжилгээ, судалгааны ажил, танилцуулгын нэр	Гүйцэтгэсэн алба, ажилтны нэр
33	Монгол Улсын хөдөө аж ахуйн салбар - 2018 онд	Ц.Сэлэнгэ, Э.Болормаа, Э.Мягмарханд
34	Монгол Улсын худалдаа, үйлчилгээний салбар - 2018 онд	Л.Энхбаатар, Ч.Мөнхтуул Э.Билгүүн
35	Зохистой хөдөлмөрийг дэмжиж 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг эрчимжүүлэх нь	АХСА
36	Ажиллах хүчний судалгааны улирлын товч танилцуулга	АХСА
37	Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан - 2018	АХСА
38	Цагаан сар ба эдийн засаг	Ч.Тунгалаг Ю.Батзоригт
39	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2018 оны танилцуулга	ӨОЗСА
40	Гэмт хэрэг, шүүхийн 2018 оны жилийн танилцуулга	Ц.Дулмаа
41	Дундаж цалингийн 2018 оны жилийн танилцуулга	Т.Оюунсүрэн
42	Соёл урлаг, биеийн тамир, спортын салбарын танилцуулга-2018	Д.Анхзаяа
43	Боловсрол, шинжлэх ухааны салбарын танилцуулга-2018	Н.Амарбаясгалан
44	Эрүүл мэндийн салбарын 2018 оны танилцуулга	Г.Урангоо
45	Хүн амын 2018 оны танилцуулга	Т.Ариунсайхан
46	ӨНЭЗС-ны улирлын танилцуулга	ӨОЗСА

ХАВСРАЛТ 6. ҮСХ-НООС 2019 ОНД ШИНЭЭР ХИЙСЭН БОЛОН ЗАСВАР, ӨӨРЧЛӨЛТ ХИЙСЭН ПРОГРАММУУД

№	Программын нэр	Тайлбар
1	Мета мэдээллийн системийн хөгжүүлэлт, шинэчлэлт	Шинэчилсэн
2	БОСТ-ын явцын мэдээ, урьдчилсан дүнгийн мэдээний программ	Шинэ
3	БОСТ-ын мэдээлэл цуглуулах программ	Шинэ
4	Хүн ам, орон сууцны завсрын тооллогын явцын мэдээ, өрхийн тэргүүлэгчийн хайлтын, урьдчилсан дүнгийн мэдээ, ангилал код, мэдээллийг шивэх программ	Шинэ
5	ХАОСТ-ын ангилал кодын программ	Шинэ
6	ХАОСТ-ын шалгагчийн өрхийн тэргүүлэгчийн хайлтын программ	Шинэ
7	ХАОСТ-ын явцын мэдээ, урьдчилсан дүнгийн мэдээний программ	Шинэ
8	ХАОСТ-ын мэдээлэл шивэх, шалгах, нэгтгэх, ахлагчийн хяналтын программ	Шинэ
9	ХАОСТ-ын ангилал кодын программ	Шинэчилсэн
10	ХАОСТ-ын шалгагчийн өрхийн тэргүүлэгчийн хайлтын программ	Шинэчилсэн
11	ХАОСТ-ын явцын мэдээ, урьдчилсан дүнгийн мэдээний программ	Шинэчилсэн
12	Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн программ (ХАӨМС)	Шинэчилсэн
13	Гадаадад оршин суугаа монгол иргэдийн бүртгэлийн программ	Шинэчилсэн
14	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үзлэг тооллогын программ	Шинэ
15	Эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагын А-ЭМТ-6 улирлын мэдээ	Шинэ
16	Ажиллах хүчний судалгааны хяналтын программ	Шинэ
17	Ажиллах хүчний 2019 оны судалгааны программд өрхийн байршлын цэг авах, өрхийн байршлаар газрын зурагт дүрслэх зэрэг засвар өөрчлөлт	Шинэчилсэн
18	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны хяналтын программ	Шинэ
19	Өрхийн нийгэм, эдийн засгийн 2019 оны судалгааны программд өрхийн байршлын цэг авах, өрхийн байршлаар газрын зурагт дүрслэх зэрэг засвар өөрчлөлт	Шинэчилсэн
20	Цаг ашиглалтын 2019 оны судалгааны 2019 (ЦАС-2019) программ	Шинэ
21	Томоохон ААНБ-ын судалгааны программ	Шинэ
22	ААНБ-ын жилийн эцсийн мэдээний программ (ААНБ1, ААНБ2)	Шинэчилсэн
23	Төмөр зам, агаарын тээврийн мэдээний Т-9, Т-7 программ	Шинэ
24	Аж үйлдвэрийн салбарын мэдээний (АУ-1) онлайн горим	Шинэ
25	Аж үйлдвэрийн салбарын мэдээний (АУ-1) программ	Шинэчилсэн
26	Төрийн бус байгууллагын улирлын мэдээний (ТББ1) программ	Шинэчилсэн
27	Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг ААНБ-ын улирлын мэдээ (БЗУ1а)	Шинэчилсэн
28	Зочид буудал, зоогийн газрын улирлын мэдээний (ЗБ1а, ЗГ1а) программ	Шинэчилсэн
29	Дотоод худалдааны мэдээний (ХУ1) программ	Шинэчилсэн
30	Аялал жуулчлалын улирлын мэдээний (АЖ1а) программ	Шинэчилсэн
31	Барилгын мэдээний (ББО) программ	Шинэчилсэн
32	Гадаад худалдааны сарын мэдээний программ	Шинэчилсэн
33	Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллогын программ	Шинэчилсэн
34	ХАА-3 сарын мэдээний программ	Шинэчилсэн
35	Хөдөө аж ахуйн сарын мэдээний программ	Шинэчилсэн
36	Хэрэглэгчийн бүртгэлийн программ, www.1212.mn хэрэглэгчийн бүртгэлийг нэгтгэж масс мэйлийг сайжруулсан.	Шинэ
37	Хүний нөөцийн программ	Шинэчилсэн
38	Орон нутгаас 14 хоногийн мэдээ авдаг программ	Шинэ
39	Дотоод үйл ажиллагааны системд нэмэлт засвар өөрчлөлт	Шинэчилсэн

ХАВСРАЛТ 7. ҮСХ-НООС 2019 ОНД ТАРХААСАН МЭДЭЭЛЭЛ

№	Тархаасан мэдээллийн нэр/агуулга	Давтамж	Хандалтын тоо	Хэрэглэгчийн тоо
A	Цахим хэлбэрээр	-	1 452 415	75 539
1.1	ҮСХ-ны цахим хуудсаар /1212.mn/	-	1 076 302	-
1.2	Mass mail	-	-	7 200
1.3	Facebook	-	-	40 144
1.4	twitter	-	-	23 995
1.5	Web /nso.mn/	-	370 113	-
1.5	Mail	-	450	450
1.6	Chat	-	3 750	3 750
Б	Хэвлэмэл байдлаар	-	15 600	
2.1	Монгол Улсын нийгэм, эдийн засгийн танилцуулга	12	3 600	300
2.2	ААНБ-ын ажиллагчдын дундаж цалингийн нугалбар	4	1 200	300
2.3	Монгол Улсын нийгэм, эдийн засгийн нугалбар	12	4 800	400
2.4	Монгол Улсын статистикийн эмхэтгэл - 2018	1	-	744
2.5	Нийгмийн зарим үзүүлэлт - 2018 /шоо хэлбэртэй олон нугалдаг нугалбар/	1	1 000	1 000
2.6	Гурвалжин нугалбар /1212.mn хуудас сурталчилгаа/	1	1 000	1 000
2.7	Номын хавчуурга /мэдээллийн эх үүсвэрүүдийг дурдсан/	1	1 000	1 000
2.8	Нийгэм, эдийн засгийн нугалбар /3 өнгөөр/	1	3 000	3 000
Б	Хэвлэлийн бага хурал	12	360	30
3.1	Хэвлэлийн бага хурал /Телевиз, веб сайт, сонин/	12	360	30
В	Телефон утас	-	1980	1980
4.1	1900-1212	-	1230	1230
4.2	11-326414	-	750	750
Г	Номын сан	-	1180	1180

ХАВСРАЛТ 8. ҮСХ-НООС 2019 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТ, ЗОРИЛТОТ БҮЛГЭЭР

№	Сургалтын сэдэв	Сургалтын хугацаа	Хамрагдсан	
			байгууллагын нэр	хүний тоо
А.	Хэрэглэгчдэд			573
1	“Хууль зүй, гэмт хэргийн статистикийн өнөөгийн байдал, статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн хэрэглээ”	1 өдөр	Хууль зүйн үндэсний хүрээлэн	15
2	“Статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн хэрэглээ, судалгаа, шинжилгээний арга зүй”	2 өдөр	Гаалийн ерөнхий газар	90
3	“Статистикийн мэдээллийн чанар, ашиглалт хэрэглээ, цуглуулсан мэдээллийн анализ шинжилгээ”	1 өдөр	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	20
4	“Статистикийн мэдээллийн хэрэглээ, ашиглалт”	1 өдөр	Авлигатай тэмцэх газар	18
5	“Статистикийн мэдээллийн чанар, шуурхай байдлыг сайжруулах нь”	1 өдөр	ЗТХЯ, зам, тээврийн салбарын албан хаагчдын сургалт	20
6	“Статистикийн мэдээллийн аргачлал, арга зүй, мэдээний маягт, анхаарах асуудал”	1-2 цагийн	Монголбанк, Авлигатай тэмцэх газар, Эрүүл мэндийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Эрүүл мэндийн хөгжлийн газар, Цагдаагийн ерөнхий газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Удирдлагын академи, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны албан хаагчдад	300
7	“Статистикийн мэдээллийн үнэ цэн”	2 өдөр	20 гаруй хэвлэл мэдээллийн байгууллага болон МҮОНРТ	30
8	“Статистик-Хэрэглээ”	1 өдөр	Монгол Улсад суугаа Элчин сайдын яамд, олон улсын байгууллагууд	20
9	“Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллын шинэчилсэн хувилбар”	2 өдөр	Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэгч нарт	60
Б.	ЕБС-ийн сурагч	2400		
1	“ЕБС-ийн үдийн хоол 2020-юу идэх вэ? Илчлэг үү? Шим тэжээл үү”	1 сар	Математик, статистикийн загварчлалын улсын II уралдаанд оролцогчид. Улсын хэмжээнд нийслэлийн 8 дүүрэг, 21 аймгийн 119 багийн ерөнхий боловсролын сургуулийн 10-12 дугаар ангийн сурагч	600
2	“Статистикийн боловсрол”	1 цаг	20 аймгийн 39 ЕБС-ийн сурагчдад	1800
В.	Оюутан сурагч			1166
1	“Статистикийн боловсрол”	1 цаг	20 аймаг, нийслэлийн их, дээд сургууль, МСҮТ	1056
2	“Их дээд сургуулиудын оюутнуудын жендэрийн статистик”, “ТХЗ, жендэрийн мэдээ мэдээлэлд дүн шинжилгээ хийх болон мэдээллийн хэрэглээ” сэдэвт сургалт	1 өдөр	НҮБ-ын эмэгтэйчүүдийн байгууллага	110
Г.	Мэдээлэгч нарт			90
1	“Статистикийн мэдээллийг веб технологид суурилсан цахим системээр хэрхэн мэдээлэх тухай”	1 өдөр	БГД, БЗД, СХД, ХУД, СБД, ЧД-ийн аж ахуйн нэгж байгууллагуудын төлөөлөл	90

№	Сургалтын сэдэв	Сургалтын хугацаа	Хамрагдсан	
			байгууллагын нэр	хүний тоо
Д.	Статистикийн ажилтанд			3897
	“Mobile Census Data Collection with CSPro Android” сэдэвт сургалт	1 өдөр	Ази, Далайн бүсийн 11 Улсын статистикийн байгууллага	30
1	“Статистикийн R программын сургалт”	2 өдөр	ҮСХ, 9 дүүргийн статистикийн хэлтэс	30
2	а/ Анхан шатны мэдээллийг сайжруулах б/ Мэдээллийн нэгдсэн сангийн уялдааг сайжруулах в/ Нээлттэй мэдээллийг бий болгох	2 өдөр	Аймаг, сумдын статистикийн асуудал хариуцсан ажилтнуудын сургалт Дорноговь, Өмнөговь, Дундговь, Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Сэлэнгэ, Булган, Хөвсгөл, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Архангай, Увс, Баян-Өлгий, Ховд аймгийн төрийн болон аж ахуйн нэгж байгууллага, сумдын ажилтнууд	3040
3	“SPSS программыг ашиглан судалгааны үр дүн боловсруулах нь”	1 өдөр	Говь-Алтай, Завхан, Баянхонгор аймгийн Статистикийн хэлтэс	20
4	“АДАПТ программ, түүний нэвтрэлт, хэрэглээ ашиглалтын талаар”	1 өдөр	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, болон Үндэсний хөгжлийн газар	16
5	“Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтны чадавх бэхжүүлэх нь”	2 өдөр	Статистикийн улсын байцаагч нарын сургалт	113
6	“Ус, хатуу хог хаягдал, агаарын бохирдлын данс байгуулах сургалт”	3 өдөр	НҮБ-ын АНДОЭЗНК, АХБ, БОАЖЯ	120
7	“Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн аргачлал”	5 өдөр	Орхон, Дархан, Увс, Завхан, Архангай аймгийн засаг даргын орлогчид, ИТХ-ын төлөөлөгчид, ЗДТГ-ын холбогдох удирдлагууд, албан хаагчид, ХХҮГ-ийн төлөөлөгчид, Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Статистикийн хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс, сум, багийн статистик мэдээ хариуцсан ажилтнууд	300
8	“Улирлын нөлөөллийг арилгах арга зүй”	1 өдөр	ҮСХ-ны болон ХНХЯ-ны статистик хариуцсан ажилтан, бусад судалгааны байгууллагын ажилтан	30
9	“Survey Solution программын сургалт”	5 өдөр	ҮСХ-ны ажилтнуудад зориулсан сургалт	18
10	“Газар зүйн мэдээллийн сан (GIS)-д тулгуурлан боловсруулсан судалгааны түүврийн загварыг боловсруулах “	3 өдөр	Газар зүйн мэдээллийн сан (GIS)-д тулгуурлан боловсруулсан судалгааны түүврийн загварын боловсруулах талаар ҮСХ-ны ажилтнууд болон бусад яам, агентлагийн мэргэжилтнүүд	20
12	“Хөдөлмөр эрхлэлтийн хугацааны цуваа/динамикийн улирлын нөлөөллийг арилгах нь”	1 өдөр	ҮСХ, ХНХЯ болон бусад судалгааны байгууллагын ажилтнуудад	30
14	“Хөдөлмөрийн статистикийн үзүүлэлтийг тооцох шинэчилсэн аргачлалын тархаалтын семинар”	1 өдөр	ҮСХ-ны төлөөлөл, бүх аймгийн Статистикийн хэлтсийн дарга, нийслэл, дүүргийн Статистикийн газар, хэлтсийн дарга нар болон холбогдох байгууллагуудын төлөөлөл	130

№	Сургалтын сэдэв	Сургалтын хугацаа	Хамрагдсан	
			байгууллагын нэр	хүний тоо
Е.	Статистикийн мэргэшүүлэх шаталсан сургалт			120
1	Анхан шатны сургалт	5 өдөр	ҮСХ, Авто тээврийн үндэсний төв, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, НЛМ, Жендэрийн үндэсний хороо, ХНХЯ	26
3	Анхан шатны сургалт	5 өдөр	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Санхүүгийн зохицуулах хороо, Биеийн тамир, спортын газар, Гадаадын иргэн, харьяатын газар, Үндэсний хөгжлийн газар, Зам, тээврийн хөгжлийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Цаг уур, орчны шинжилгээний газар, Гаалийн ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн соёл урлагийн газар, Стандарт, хэмжил зүйн газар, Авлигатай тэмцэх газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Барилгын хөгжлийн төв, ХХААХҮЯ, Цагдаагийн ерөнхий газар, Төрийн албаны зөвлөл, БОАЖЯ, ХНХЯ, БСШУСЯ, ЭМХТ, НЭМГ	30
2	Дунд түвшний I шат	5 өдөр	ҮСХ, ЭМЯ-ны Эрүүл мэндийн хөгжлийн төв, Цагдаагийн ерөнхий газар	23
4	Дунд түвшний II шатны сургалт	5 өдөр	Гаалийн ерөнхий газар, БОАЖЯ, БХБЯ, Стандарт, хэмжил зүйн газар, Онцгой байдлын ерөнхий газар, Цаг уур, орчны шинжилгээний газар, Үндэсний аудитын газар	21
5	Ахисан түвшний сургалт	5 өдөр	ҮСХ, Нийслэлийн соёл урлагийн газар	20
Ё.	Судалгааны мэдээлэл цуглуулах судлаач нар			1445
1	Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны сургалт, семинар	16 өдөр	УИХ-ын ТГ, 19 аймаг, 6 дүүргийн ЗДТГ, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Эмэгтэйчүүдийн ТББ, ЦЕГ, Нэг цэгийн үйлчилгээний төв, БСГ, ЭМГ, ЕБС	
	1150			
2	АХС-ны болон ӨНЭЗС-ны мэдээлэл цуглуулах	5 өдөр	АХС-ны болон ӨНЭЗС-ны мэдээлэл цуглуулах багийн ахлагч, судлаач нарын сургалт	115
3	Байшин, орон сууцны тооллогын мэдээлэл цуглуулах, шалгах тухай	18 өдөр	Байшин, орон сууцны тооллогын судлаач нарын сургалт	108
4	Хүн ам, орон сууцны улсын тооллогын мэдээлэл цуглуулах, шалгах	4 өдөр	Хүн ам, орон сууцны улсын тооллогын судлаач нарын сургалт	72
	Нийт дүн			9691

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО